



# ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

БАЙГУУЛЛАГА: МУИС-ИЙН ОУХНУС  
ХӨТӨЛБӨР: ТӨРИЙН УДИРДЛАГА

**Шинжээчийн баг:**

Ахлагч: Ц.Гэлэгжамц, доктор, профессор

Гишүүд: Л.Оюунцэцэг, доктор, профессор

Я.Бямбаяр, доктор, дэд профессор

## ГАРЧИГ

<b>I. ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЙЛ ЯВЦ, ТАЙЛАГНАЛТ .....</b>	<b>2</b>
<b>II. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА.....</b>	<b>3</b>
<b>III. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ.....</b>	<b>4</b>
ШАЛГУУР 1: ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ .....	4
ШАЛГУУР 2: СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	8
ШАЛГУУР 3: ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ	11
ШАЛГУУР 4: ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....	16
ШАЛГУУР 5. СУРАЛЦАГЧДАД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	21
ШАЛГУУР 6. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	30
ШАЛГУУР 7. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ .....	36
ДҮГНЭЛТ .....	41
<b>IV. ЯРИЛЦЛАГАД ОРОЛЦОГЧДЫН НЭРС .....</b>	<b>43</b>
1) Багш нар .....	43
2) Оюутнууд .....	43
3) Ажил олгогчид .....	43
4) Төгсөгчид .....	44

## I. ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЙЛ ЯВЦ, ТАЙЛАГНАЛТ

Сургуулийн нэр (монгол, англи)	Монгол Улсын Их сургуулийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль/ School of International Relations and Public Administration, National University of Mongolia	
Сургалтын хөтөлбөрийн нэр (монгол, англи)	Төрийн удирдлага Public Administration	
Индекс	<b>D041303</b>	
Шинжээчид	Багийн ахлагч: Ц.Гэлэгжамц, Оточ манрамба их сургуулийн Магистр докторын сургалтын албаны дарга Багийн гишүүн: Л.Оюунцэцэг, ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн профессор Багийн гишүүн: Я.Бямбаяр, Удирдлагын академийн Сургалтын албаны дарга	
БМИҮЗ-ийн мэргэжилтэн	Г.Даваажаргал	
Төлөвлөгөө	<b>Он, сар, өдөр</b>	<b>Хийх ажил</b>
	2020.06.02	Мэргэжилтэн шинжээчдийн нэрсийг хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багт илгээж, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар саналыг хүлээн авах
	2020.06.02	Шинжээчийн багийг томилох
	2020.06.02	Шинжээчидтэй гэрээ байгуулах
	2020.06.02	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгөх
	2020.06.08	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө
	2020.06.08	Мэргэжилтэн сургууль дээр очиж, шинжээчид ажиллах бэлтгэл хангуулна
	2020.06.09-10	Шинжээчид сургууль дээр ажиллана
	2020.06.19	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө
	2020.06.22	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна
	2020.06.23	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө
	2020.06.25	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ
		Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчдийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ
<b>Шалгуур, шаардлага (журам)</b>	БМИҮЗ-өөс эрхлэн мөрдүүлж буй Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд мөрдөх заавар, журмууд, Шинжээчийн үнэлгээний тайлан, холбогдох бусад заавар, эрхийн баримт бичиг, БМИҮЗ-ийн Ажлын албаны захирлын 2020 оны А/28 дугаар тушаал.	

## II. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

МУИС-ийн ОУХНУС-ийн Нийтийн удирдлагын тэнхимийн “Төрийн удирдлага” бакалаврын хөтөлбөр нь 2011-2012 оны хичээлийн жилээс “Менежмент-Төрийн захиргаа” гэсэн нэршилтэйгээр МУИС-ийн Бизнесийн удирдлагын сургуульд хэрэгжиж эхэлсэн. 2014-2015 оны хичээлийн жилээс “Нийтийн удирдлага” хөтөлбөр болгон шинэчилж, 2016 оноос “Нийтийн удирдлага”-ын хавсарга хөтөлбөрийг боловсруулан батлуулжээ. 2017 онд БСШУС-ын сайдын А/52 дугаар тушаалаар “Нийтийн удирдлага” хөтөлбөрийн “Нийтийн” гэснийг “Төрийн” гэж зөвхөн нэршлийг өөрчлөн “Төрийн удирдлага” болгосон. Харин хөтөлбөрийн агуулга, зорилт, хүрэх үр дүн, хөгжлийн чиглэл, төгсөгчдийн загвар зэрэг хөтөлбөрийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулаагүй байна. Мөн онд гадаадын 4 орны, дотоодын 3 их, дээд сургуулийн хичээлүүдтэй харьцуулсан судалгаа хийсэн нь хөтөлбөрийн төлөвлөлтийг сайжруулах үндэслэл болжээ.

Энэхүү хөтөлбөр нь Нийтийн удирдлагын тэнхимд хэрэгждэг. Тус тэнхимд 6 үндсэн багш (тэнхимийн эрхлэгчийг оролцуулаад) ажилладгаас гадна сүүлийн 6 хичээлийн жилд ХБНГУ, АНУ-аас жил бүр 1-3 нэр хүндтэй эрдэмтдийг тэнхимдээ “Зочин профессор”-оор тасралтгүй ажиллуулж байгаа нь тэнхимийн багш нарыг чадавхжуулах, гадаад хэлний чадварыг дээшлүүлэх, оюутны сурах хүслийг нэмэгдүүлэх, хөтөлбөрийн нэр хүнд, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд ач холбогдолтой байгаа нь Монголын их, дээд сургуульд хэрэгжүүлүүштэй онцлог үйл ажиллагаа юм. Тухайлбал, ХБНГУ-ын Шпайерийн Төрийн удирдлагын их сургуулийн докторантурт тус тэнхимийн 3 багш эчнээ суралцсанаас 1 багш докторын зэрэг хамгаалж, 2 багш судалгааны ажлаа хийж байна.

Нийтийн удирдлагын тэнхимээс эрхлэн Төрийн удирдлага хөтөлбөрийн хүрээнд олон улсын төсөл, хөтөлбөрт хамтран оролцдог, гадаадын нэр хүндтэй эрдэмтдийг урьж, тэдгээрийн оролцоотойгоор төрийн удирдлагын орчин үеийн тулгамдсан асуудлаар Олон улсын эрдэм шинжилгээний хурал, олон нийтийн лекц, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулж, тэдгээрт шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлдэг, БНСУ-ын Hansung их сургуультай хамтран олон улсын стандарт ISSN 2586-355X -ын дугаартай International Journal of Public Administration and consulting (IJPAC) сэтгүүлд “NUM Leadership” ОУ-ын ЭШХ-ын эмхэтгэлийг жил бүр тогтмол хэвлүүлдэг болсон зэрэг нь энэхүү хөтөлбөрийн цар хүрээг өргөжсөнийг илтгэн харуулж байна.

2019 онд МУИС-ийн Орхон, Завхан аймаг дахь салбар сургуулиудтай 2+2 хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэхээр сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулжээ.

2016-2020 онд Төрийн удирдлага хөтөлбөрөөр 137 хүн төгссөн (жилд 19-41 хүн), төгсөгчдийн голч дүн 2.76-3.08 байна (ӨҮТ, Хүснэгт 7.5). Сүүлийн жилүүдэд Төрийн удирдлага мэргэжлээр төгсөгчдийн тоо харьцангуй цөөрсөн байна.

### III. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

#### ШАЛГУУР 1: ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

##### 1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

##### **Илрэл, нотолгоо:**

- ✓ Төрийн удирдлага хөтөлбөрийн зорилгыг “Төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллага, бизнесийн болон төрийн бус байгууллагуудад менежментийн чиглэлээр ажиллах, түүнд өөрийгөө бэлтгэн суралцах хүсэлтэй оюутнуудад шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлага олгоход оршино.” гэж тодорхойлсон нь энэхүү хөтөлбөрийн хэрэгцээний талбарыг нэлээд өргөн хүрээнд авч үзсэнийг харуулж байна.
- ✓ “Төрийн удирдлага” бакалаврын хөтөлбөрийг боловсруулахад төрийн удирдлагын ирээдүйн чиг хандлагын STEEP шинжилгээг Улс төр-эрхзүй, Эдийн засаг, Хүрээлэн буй орчин, Нийгэм-хүн амзүй, Технологийг хамруулан хийж, боломж, сорилтууд, ажлын байрны ирээдүйг тодорхойлсон байна. 2011 оноос мөрдөж эхэлсэн “Менежмент-төрийн захиргаа” гэсэн бакалаврын хөтөлбөрийг 2014 онд шинэчлэн “Нийтийн удирдлага” нэртэйгээр батлуулан мөрдөж байна (Хавсралт 1.5). 2017 онд энэ хөтөлбөрийн зөвхөн нэрийг “Төрийн удирдлага” болгон өөрчилжээ.
- ✓ 2017 онд “Төрийн удирдлага” бакалаврын мэргэжлийн хөтөлбөрийг гадаад, дотоодын ижил мэргэжлийн хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгааг хийж, хөтөлбөрийн зорилго, агуулга, хэрэгжүүлэх арга зүй, хөтөлбөрийн үр дүн нь бусад сургуулийнхтай нийцэж байна гэж үнэлж, хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээ тодорхойлж, сайжруулалт хийхээр төлөвлөж байна.
- ✓ Хөтөлбөрийн хүрээнд эзэмших мэдлэг, ур чадварыг харьцуулж үзэхэд төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд төрийн албан хаагчийн хувьд бүх салбарын шинжлэх ухааны мэдлэгийг системтэй эзэмшсэн, салбар шинжлэх ухаануудын хоорондын уялдаа холбоог ойлгож мэдэх, бусад салбар хооронд хөрвөх чадвар бүхий мэргэшсэн, аливаа өөрчлөлтөд түргэн дасан зохицох, хариу арга хэмжээ, шийдвэр гаргах чадвар бүхий төрийн албан хаагчдыг бэлтгэн хөдөлмөрийн зах зээлд нийцүүлэхэд чиглэгдсэн байна.
- ✓ Хөтөлбөрийн төлөвлөлтийг хийхэд ХБНГУ, АНУ, Франц, Их Британи, Канад, БНСУ-ын зарим их сургуулийн ижил төрлийн хөтөлбөртэй голчлон харьцуулсан судалгаа хийсэн бол, хөрш орнууд болох ОХУ, БНХАУ-ын их сургуулиудын сургалтын хөтөлбөртэй харьцуулаагүй байна.

**Онцлог зүйл, туршлага:**

- ✓ “Төрийн удирдлага” бакалаврын хөтөлбөр нь оюутны бие даан судалгааны ажил хийхийг дэмжсэн, нийгмийн шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлээр хичээлүүдийг сонгон судлах боломжоор хангагдсан.
- ✓ Олон улсын нэр хүндтэй зөвлөх профессоруудын илтгэл, лекцийг сонсох, зөвлөгөө авах боломжтой, ингэснээр элсэгч, оюутанд Төрийн удирдлага мэргэжлийг эзэмших хүсэл, итгэл төрүүлэхэд нөлөөлж байна.

**Анхаарах асуудал:**

- ✓ Төрийн удирдлага хөтөлбөрт 3 жилийн өмнө гадаад, дотоодын ижил төрлийн сургуулиудтай харьцуулсан судалгаа хийж, хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээ тодорхойлсон боловч одоогоор сайжруулалт хийх үйл явц төлөвлөлтийн шатанд байна.
- ✓ “Төрийн удирдлага” бакалаврын мэргэжлийн хөтөлбөрийг гадаад, дотоодын ижил мэргэжлийн хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгааны үр дүн болон хөтөлбөрийн агуулга, онцлог, давуу талуудын талаарх танилцуулга, сурталчилгааг оролцогч талуудад хүргэхдээ хангалттай биш.

**Зөвлөмж:**

- ✓ 2017 оноос хойших хугацаанд хөтөлбөртэй холбогдуулан хийсэн харьцуулсан судалгаануудын үр дүн болон оролцогч талуудын саналын дагуу Төрийн удирдлага хөтөлбөрийн сайжруулалтыг 2020-2021 оны хичээлийн жилд багтаан хийж, батламжлан мөрдөх.

**1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

**Илрэл, нотолгоо:**

- ✓ 2014 онд Төрийн удирдлага хөтөлбөрийн зорилгыг “Төрийн удирдлага хөтөлбөр нь удирдахуйн ухаан, нийгэм, хууль эрх зүйн шинжлэх ухаанд суурилсан удирдлагын мэргэжилтэн бэлтгэх, төрийн удирдлагын шинжлэх ухааныг бусад салбар ухаантай уялдаа холбоотойгоор хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, олон талт мэдлэг бүхий чадварлаг мэргэжилтэн бэлтгэхэд оршино.” гэж тодорхойлсон байна. Хөтөлбөрийн зорилгыг МУИС-ийн эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөтэй уялдуулсан.
- ✓ 2019 онд “Дээд боловсролын шинэчлэл төсөл”-ийн үр дүнд суурилсан сургалтын аргагүй (CDIO)-д нийцүүлэн Төрийн удирдлага хөтөлбөрийн үр дүн буюу төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлагыг 15 цогц чадамжаар илэрхийлсэн жишиг төгсөгчийн загварыг тодорхойлсон нь шинэлэг зүйл болжээ.

## Төрийн удирдлага хөтөлбөрөөр төгсөгчийн мэдлэг, чадвар, хандлага



**Мэдлэг:**

Төр, нийтийн удирдлагын ШУ-ы мэдлэгээ ашиглаж хэрэглэж занших,  
Бодлогын асуудлын үндсийг тодорхойлох  
Төлөвлөх,  
Хэрэгжүүлэх  
Хянах, дахин хянах, тасралтгүй сайжруулах  
Бодлогын шинжилгээ, салбар хоорондын уялдааг оновчтой хангах  
Системтэй стратегич бодлого боловсруулах, хэрэгжүүлэх



**Чадвар:**

Байгууллагын алсын эрхэм зорилго, зорилт, стратеги төлөвлөгөөтэй уялдсан бодлого боловсруулах, хэрэгжүүлэх  
Технологийн дэвшилд суурилсан төрийн бодлого үйлчилгээг иргэдэд хүргэх  
Мэргэжлийн түвшинд удирдан чиглүүлэгч манлайлагч байх  
Мэдлэгийг баялаг болгох  
Глобал, системтэй сэтгэх  
Асуудлыг тодорхойлох, санаачлагатай, шийдвэрлэхэд оролцох хүсэл эрмэлзэлтэй байх  
Бүтээлч, шинийг эрэлхийлэгч байх



**Хандлага:**

Иргэдийг ойлгох чадвар  
Аль ч нийгмийн орчинд дасан зохицох  
Тухайн нийгмийн орчин нөхцөлийг нарийн мэдэрч асуудалд хуулийн хүрээнд тууштай бодитой хандах  
Шинийг эрэлхийлэгч, санаачлагч байх  
Хувь хүний болон мэргэжлийн өндөр ёс зүйтэй байх  
Нийгмийн болон хувь хүний хариуцлага

- ✓ Хичээлийн залгамж холбоо, хичээлийг зохион байгуулах хэлбэр (тонгоруу сургалт, багаар суралцах, бие даах, дүрд тоглох, мэтгэлцэх зэрэг)-үүд, үнэлгээний шинэлэг аргуудыг нэмэгдүүлсэн нь хөтөлбөрийг зах зээлийн шаардлагад нийцүүлэхэд чиглэгдсэн байна.

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

### **Зөвлөмж:**

- ✓ Цаашид 21-р зууны дээд боловсролын шинэчлэл, тогтвортой хөгжлийн зорилтууд, мэдээллийн технологийн хөгжил, цахим засаглал, дижитал хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцүүлэн хөтөлбөрийн зорилго, зорилтыг шинэчлэн тодорхойлохыг зөвлөж байна.

### **1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

### **Илрэл, нотолгоо:**

- ✓ Төрийн удирдлага бакалаврын хөтөлбөрийг боловсруулахдаа дээд боловсролын салбарт мөрдөж байгаа хууль, бодлого, дүрэм, журам, нийтлэг шаардлага, хөтөлбөр, төлөвлөгөө, стандарт, заавар, зөвлөмжийг удирдлага болгосон байна.
- ✓ “Нийтийн удирдлага” хөтөлбөрийг МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хорооны 2014 оны 06-р сарын 25-ны хурлаар хэлэлцэн баталсан. “Либерал арт” системд буюу либерал боловсролд суурилсан бөгөөд сургалтын төлөвлөгөөний агуулгын багтаамж, бүтэц нь Бакалаврын хөтөлбөрт тавигддаг нийтлэг шаардлагад нийцэж байна.

- ✓ Төрийн удирдлага бакалаврын хөтөлбөрт орсон хичээлийн хөтөлбөрүүдэд суралцагчдын чөлөөт сонголтыг харгалзан үзсэн, тухайн хичээлээр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үр дүнгийн үнэлгээг багтааж, тэнхим, хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцүүлэн баталгаажуулсан байна.

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

***Зөвлөмж:***

- ✓ Хөтөлбөрийн баримт бичгүүдийг үе шаттайгаар, хэсэгчилсэн байдлаар боловсруулан мөрдөж байгаа боловч “Төрийн удирдлага” бакалаврын хөтөлбөрийг БСШУ-ны сайдын 2014 оны А/174 дүгээр тушаалаар баталсан шаардлагын дагуу иж бүрэн байдлаар боловсруулж, баталгаажуулан мөрдөхийг зөвлөж байна.

***Нэгдүгээр шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:***

**“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”**



## **ШАЛГУУР 2: СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### **Илрэл, нотолгоо:**

- ✓ Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн буюу хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцсэн болохыг Сургалтын төлөвлөгөө болон Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн матрицаар үзүүлсэн байна. Сургалтын төлөвлөгөөнд орсон хичээл бүрийн агуулгыг шалгуур үзүүлэлтээр авч үзэн хичээлүүдээр олгох мэдлэг, ур чадварыг тодорхойлсон байна. Хичээлүүдийн агуулга нь мэргэжлийн чиглэл, онцлог, эзэмшвэл зохих мэдлэг, чадвартай нийцтэй байгааг нотолсон байна.
- ✓ Хичээлүүдийн харилцан уялдаа, онол, практикийн харьцаа нь зохистой хэмжээнд байна. Хичээлийн хэлбэр нь лекц, семинар хосолсон хэлбэртэй явдаг. Лекцээр онолын мэдлэг олгож, семинарын ажлын хүрээнд практик дасгал, кейсэд суурилсан судалгааны ажлуудыг хийж, онолын мэдлэгээ бататгах байдлаар зохион байгуулсан байна. Мэргэжлийн суурь, мэргэжлийн заавал судлах 35 хичээлийн агуулгын 94.2 хувийг онол, 31.4 хувийг практик эзэлж байгаа хэмээн ӨҮТ-д тусгасан байна. (ӨҮТ, 18-19 дэх тал) Онол, практикийн харьцааг ойролцоогоор 3:2-ын харьцаатай байна гэж үзэв.

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

#### **Онцлог зүйл, туршлага:**

- ✓ Сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа Германы болон АНУ-ын их сургуулиудад бакалаврын түвшинд зааж байгаа сургалтын хөтөлбөр, хичээлийн агуулгыг судалж, гадаад, дотоодын их сургуулиудын тухайн мэргэжлийн туршлагатай багш нарын саналд үндэслэл болгосон нь онцлог байна.

#### **Анхаарах асуудал:**

- ✓ Сургалтын хөтөлбөр нь суралцагчийг нэлээд ерөнхий мэргэжилд бэлтгэдэг чиглэлтэй байгаа тул төгсөгчийг төрийн албанд ажиллахад бэлтгэх тал дээр анхаарах.

#### **Зөвлөмж:**

Суралцагчдын болон ажил олгогчдын хэрэгцээг тогтмол судалж, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгоход ашигладаг байх.

## 2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

### **Илрэл, нотолгоо:**

- ✓ Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн байна. Үр дүнд суурилсан боловсрол CDIO-н арга зүйн дагуу тус хөтөлбөрийн хичээлүүд нь кейсэд суурилсан, төсөлд суурилсан аргуудыг нэлээд ашигладаг байна. Багш нарын заах арга зүй болон сургалтын хөтөлбөрийг сайжруулах зорилгоор CDIO тогтолцоог нэвтрүүлж, сургагч багш нарыг бэлтгэсэн.
- ✓ Хичээлүүдэд ашигладаг хамгийн түгээмэл арга нь лекц (94.3%) боловч мэтгэлцээн (62.9%), зарчмын асуулт/хариултын арга (45.7%)-ыг мөн хэрэглэдэг байна. Сургалтын арга нь суралцагчдыг мэдлэг бүтээх, түүнийгээ хэрэглэхэд чиглүүлсэн гэж ӨҮТ-д бичсэн байна (ӨҮТ, 22 дахь тал). Суралцагчийг бие даан суралцахад дэмжлэг болох зорилгоор багш нар тусгайлсан зөвлөгөө өгөх цагтай бөгөөд энэ цагийн явцад ганцаарчлан болон бүлгээр нь зөвлөгөө өгөх, бие даалтын даалгаврыг шалгах зэргээр суралцах үйл явцад хяналт тавин ажилладаг байна. Харьцангуй цөөн оюутантай учир багш нар оюутантай харилцах, зөвлөгөө өгөх, арга зүйн дэмжлэг үзүүлэх боломж төдий чинээ их байгаа нь харагдав.
- ✓ Сургалтын техник хэрэгсэл ашиглах явдал түгээмэл (хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш суралцагчдын 76-90 хувь үүнд сэтгэл ханамжтай), үр дүн сайтай байна.

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

### **Анхаарах асуудал:**

- ✓ МУИС-ийн сургалтын мэдээллийн систем (СиСи)-ийг ашиглан сургалтын материалыг хүргэдгээс гадна зайн сургалтын хичээл бэлтгэх талаар анхаарах.

### **Зөвлөмж:**

- ✓ Зайн сургалтын хичээл боловсруулах, багш нар зайн сургалтын арга зүйд суралцах.

## 2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

### **Илрэл, нотолгоо:**

- ✓ Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлж дүгнэх гол хэлбэр нь шалгалт байна. Семинар, дадлагын ажил, судалгаа, бусад бие даалтын ажлаар эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлэхэд төсөл, тайлан хамгаалалт, явцын шалгалт, тест,

- ангийн ажил болон тэдгээртэй дүйцэх бусад хэлбэрийг ашигладаг. Мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлээр хийх дадлагад багц цаг харгалзуулсан бол тэдгээрийн тайлангийн хамгаалалтыг шалгалтын нэг адил үзэж оноогоор үнэлнэ. Энэ нь МУИС-ийн хэмжээнд мөрдөж буй үнэлгээний нэгдсэн системд хамаарна.
- ✓ Суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх оноо нь 100 байх бөгөөд явцын үнэлгээ, идэвх оролцооны үнэлгээ, улирлын шалгалтын онооны нийлбэрээс бүрддэг байна.
  - ✓ Шалгалтын зонхилох хэлбэр нь сорил (89%), аман илтгэл 54.7%, хэлэлцүүлэг 54.3% байна. Багш тухайн хичээлээр дүгнэх аргачлалыг урьдчилан мэдэгдэнэ. Багшийг дүнгээ Сиси системд оруулмагц суралцагчид өөрийн үнэлгээг олж харах боломжтой. Суралцагч өөрийн үнэлгээнд дүгнэлт хийх үүрэгтэй болдог.
  - ✓ Сургалтын арга зүй, үнэлгээний аргачлалыг бодитой байлгах, тасралтгүй сайжруулах чиглэлд хийсэн ажлын талаар мэдээлэл хомс байв.

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

***Анхаарах асуудал:***

- ✓ Сорилоос гадна тодорхой ур чадвар эзэмшсэн эсэхийг шалгах үнэлгээний арга нэвтрүүлэх талаар ажиллах.

***Зөвлөмж:***

- ✓ Үнэлгээний аргачлалыг хичээл бүрийн хэлбэр, онцлог, агуулгад нийцүүлэн сайжруулах талаар судалгаа хийх, хөтөлбөрийг сайжруулах үйл явцын бүрэлдэхүүнд тогтмол анхаарч үзэж байх нь зүйтэй.

***Хоёрдугаар шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:***

**“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”**

### **ШАЛГУУР 3: ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### **3.1. Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### **Илрэл, нотолгоо:**

- ✓ Төрийн удирдлага хөтөлбөрийг хэрэгжүүлэгч үндсэн нэгж - Нийтийн удирдлагын тэнхим нь МУИС-ийн 5-р байранд байрладаг тул хичээл сургалтын үйл ажиллагаа энд төвлөрдөг. Хөтөлбөрийг хариуцсан сургууль, тэнхим нь өөрийн хичээлийн байртай, сургалтын анги танхим, техник хэрэгслээр харьцангуй сайн хангагдсан.
- ✓ Хөтөлбөрт хамаарах 90-150 суудалтай 3 лекцийн танхим, 26-40 суудалтай семинарын 11 ангитай. 150-аас дээш оюутантай хичээлүүд МУИС-ийн Төв номын санд болон 2, 4-р байруудад ордог. Лекц, семинарын анги танхимуудын тохижилт сайн, сургалтын техник хэрэгслээр бүрэн хангагдсан.
- ✓ ОУХНУС-ийн хичээлийн байр нь 8000 гаруй номын фонд бүхий 24 суудалтай номын сантай, ЭШ-ний уншлагын танхимтай. Мөн МУИС-ийн Төв номын сангийн нөөцөөс хөтөлбөрийн оюутнууд ашиглах боломжтой.
- ✓ НУТ-ийн багш нар ажлын 4 өрөөтэй. (401, 402, 406, 407 тоот) Компьютер, хувилах, хэвлэх техник хэрэгслээр бүрэн хангагдсан. Гадаадын зочин профессоруудын өрөөг бүрэн тохижуулсан (407 тоот).
- ✓ БНСУ-ын Хансоны их сургуультай хамтран 2016-2018 онуудад хэрэгжүүлсэн “МУИС-ийн НУТ-ийг чадавхжуулах төсөл”-ийн шугамаар КОИСА-ийн 278 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар орчин үеийн техник хэрэгслээр бүрэн тоноглогдсон онлайн сургалтын танхим (“Cyber Education center”) байгуулж, хичээл сургалтад тогтмол ашигладаг. (МУИС-ийн 5-р байр, 303 тоот өрөө)
- ✓ Оюутны сэтгэл ханамжийн судалгаагаар сургалтын орчны үнэлгээ 2015 онд 75% байсан бол 2016-2019 онд 80-аас дээш хувиар сайн гэж үнэлэгдсэн. Ингэж оюутны үнэлгээ өссөн нь сургалтын орчин тэдний хүлээлт, шаардлагад нийцэж байгаагийн илэрхийлэл болж байна. Түүнчлэн, оюутнууд болон төгсөгчидтэй хийсэн ярилцлагын дүнгээс үзэхэд сургалтын орчны талаар дутагдалтай зүйлс дурдаагүй болно.
- ✓ ОХУНУС, Нийтийн удирдлагын тэнхим, МУИС-ийн Төв номын сан, сургуулийн номын сан, хичээлийн анги танхимууд, багш нарын ажлын өрөө зэрэгтэй танилцсан шинжээчийн багийн ажиглалтын явцаас үзэхэд нь тус сургууль, тэнхимийн хувьд Төрийн удирдлагын хөтөлбөр хэрэгжүүлэх сургалтын орчин хангалттай түвшинд бүрдсэн байна хэмээн дүгнэж болохоор байна.

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

### **Онцлог зүйл, туршлага:**

- ✓ Хөтөлбөрийг хариуцсан сургууль, тэнхим нь өөрийн хичээлийн байртай, сургалтын анги танхим, техник хэрэгслээр харьцангуй сайн хангагдсан.
- ✓ МУИС-ийн Төв номын сан нь орчин үеийн их сургуулийн номын сангийн шаардлагад бүрэн нийцсэн орчин бүрдүүлсэн. Уншлагын танхимууд, багаар ажиллахаар тусгаарласан өрөөнүүд, амрах хэсгүүдтэй. Багш, оюутнууд тав тухтай үйлчлүүлэх өргөн боломж бүрдүүлсэн.
- ✓ Сургалтын орчинг сайжруулах чиглэлээр тэнхимийн удирдлага, хамт олны зүгээс ихээхэн идэвх санаачилгатай ажиллаж, багагүй хөрөнгө оруулалт хийж, орчин үеийн техник хэрэгслээр тоноглогдсон Цахим сургалтын танхим байгуулсан.

### **Анхаарах асуудал:**

- ✓ ОУХНУС-ийн байранд оюутнуудын цайны газар байхгүй;
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих стандарт нөхцөл хангагдаагүй;
- ✓ Оюутнуудын хоол, эрүүл мэндийн үйлчилгээний талаар мэдээлэл дутмаг.

### **Зөвлөмж:**

- ✓ Дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэх боломжийг эрж хайх;
- ✓ Хөтөлбөрийн танилцуулга, мэдээлэлд сургалтын орчин, оюутны нийгмийн үйлчилгээ (хоол, эрүүл мэндийн г.м.)-ний талаар мэдээлэл оруулах нь хөтөлбөрийн сурталчилгаанд тустай.

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

### **Илрэл, нотолгоо:**

- ✓ Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч сургууль, тэнхим нь сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгслээр харьцангуй сайн хангагдсан, орчин үеийн техник хэрэгслээр бүрэн тоноглогдсон онлайн сургалтын танхимтай. (МУИС-ийн 5-р байр, 303 тоот өрөө)
- ✓ Багш нарын сургалтын хэрэглэгдэхүүний шинэчлэлд сургуулийн зүгээс жил тутам тодорхой хөрөнгө зарцуулж ирсэн, сүүлийн жилүүдэд хэмжээ нь нэмэгдсэн. (2013-2014 оны хичээлийн жилд 7.16 сая төг. байсан бол 2018-2019 онд 59.65 сая төг. зарцуулсан- Өөрийн үнэлгээний тайлан: Хуудас. 32-33)
- ✓ Багш нар лицензтэй программ ашигладаг (Kaspersky, Bolorsoft г.м.) ба сургуулийн орчинд WiFi – утасгүй интернэттэй.
- ✓ Орчинтой танилцсан шинжээчийн багийн ажиглалтаас үзэхэд хичээлийн анги танхимууд, багш нарын ажлын өрөөнүүд шаардлагатай техник хэрэгслээр боломжийн түвшинд хангагдсан байгаа нь харагдаж байв. Оюутны сэтгэл ханамжийн судалгаа, мөн оюутнууд болон төгсөгчидтэй хийсэн ярилцлагын дүнгүүд дээрхийг нотолж байна.

**Онцлог зүйл, туршлага:**

- ✓ Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгж буюу НУТ-ийн чадавхыг сайжруулах төсөл хэрэгжүүлснээр сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулахад томоохон түлхэц болсон.
- ✓ Тэнхимийн хамт олон GIZ, UNDP зэрэг олон улсын байгууллага, KAS зэрэг их сургуулиудтай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн нь сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулах давхар боломж олгосон.
- ✓ Цахим сургалтын танхимаа ашиглан мэргэжлийн 300 кодтой гурван хичээлийг E-хэлбэрээр заасан ба бусад хичээлийг онлайнгаар заах бэлтгэл хангаж, хэсэгчилсэн туршилтууд хийгдэж байгаа нь сайшаалтай.

**Анхаарах асуудал:**

- ✓ Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийн талаар тодорхой мэдээлэл тайланд тусгагдаагүй;
- ✓ Өөрийн үнэлгээний тайланд дурдсанаар сургуулийн орчинд ажилладаг утасгүй интернэт –Wi-Fi сүлжээ доголдох, зарим анги, танхимын интернэт сүлжээ удаан байдаг зэргээс шалтгаалан мэдээлэл хайх, харилцахад хүндрэл учирдаг;

**Зөвлөмж:**

- ✓ Сургалтын заавар, удирдамж, зөвлөмжүүдийг нэгтгэн багцалж, мэдээллийн тодорхой байдлыг хангах;
- ✓ Сургуулийн орчинд ажилладаг утасгүй интернэт – Wi-Fi сүлжээний ачаалал даах чадварыг сайжруулах, зарим анги, танхимын интернэт сүлжээний удаашралыг арилгах арга хэмжээ авах;

**3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

**Илрэл, нотолгоо:**

- ✓ Хөтөлбөр хэрэгжүүлэгч ОУХНУС нь өөрийн хичээлийн байранд 8000 гаруй ном, сурах бичиг, сэтгүүлтэй, 38 суудалтай уншлагын танхимаар оюутнуудад үйлчилдгээс гадна МУИС-ийн Төв номын сан нь нийт 360000 гаруй хэвлэмэл болон цахим ном, сонин, сэтгүүлийн фондтой, 1000 орчим CD, зохиогчийн эрхтэй 20 гаруй цахим ном, 2000 гаруй магистрын ажил, олон улсын 16 томоохон мэдээллийн санг оюутнууд мөн ашиглах боломжтой.
- ✓ Тэнхимийн удирдлага, багш нар мэргэжлийн ном сурах бичгээр хангах талаар ихээхэн санаачилгатай ажиллаж 2015 оноос хойших хугацаанд 9 ном, сурах бичиг бичиж, хэвлүүлэн, хичээл сургалтад ашиглаж байна. Түүнчлэн тэнхимийн зүгээс олон улсын хурал, хэлэлцүүлэг зэрэг арга хэмжээг жил бүр тогтмол зохион байгуулж, илтгэлүүдийг эмхэтгэл болгон хэвлүүлдэг, олон улсын индекс

- бүхий сэтгүүл 2017 оноос эрхлэн гаргаж байгаа зэрэг нь оюутнуудад судалгаа, сургалтын хэрэглэгдэхүүн болон өргөн ашиглагдаж байна.
- ✓ НУТ-ийн хамтын ажиллагаатай олон улсын байгууллага, их сургуулиуд, гадаадын зөвлөх профессоруудын тусламжтайгаар мэргэжлийн ном, сурах бичгийн хангамжийг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлж ирсэн байна.
  - ✓ Түүнээс гадна, олон улсад түгээмэл эрдэм шинжилгээний мэдээллийн сангууд (Ebsco, Royal society, PNAS, Spie digital library, Springer, Agora, Ardi, Hinari, Qare, Global Online Access To Legal Information г.м.)-ийн эрхийг авч, ашиглах боломж бүрдүүлсэн ба МУИС-ийн эрдэм шинжилгээний бүтээлийн мэдээллийн санг хүртээмжтэй болгох зорилгоор Ebsco Host нэгдсэн мэдээллийн сангаас eBook Academic collection, Academic Search Premier, Business Source Premier гурван багцыг захиалан ашигладаг.
  - ✓ Номын сангийн ашиглалтын хувьд цахим каталог КОНА систем ашиглах, магистрын судалгааны ажлууд 100% цахим хэлбэрт шилжсэн бөгөөд МУИС-ийн суралцагч бүр сургуулийн сүлжээнээс холбогдож, шууд ашиглах давуу талтай.
  - ✓ Сургуулийн зүгээс ном сурах бичиг худалдан авах хөрөнгө оруулалтыг жил тутам тасралтгүй хийж, жил бүр 2.24 саяас 17.74 сая төгрөг зарцуулж иржээ.
  - ✓ Оюутны сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, оюутнууд болон төгсөгчидтэй хийсэн ярилцлагын үр дүнгээс үзэхэд мэргэжлийн ном сурах бичгийн хангамж сүүлийн жилүүдэд сайжирсан болох нь харагдаж байна.

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

**Онцлог зүйл, туршлага:**

- ✓ МУИС-ийн хувьд орчин үеийн их сургуулийн номын сангийн шаардлагад бүрэн нийцсэн томоохон номын сан байгуулан ажиллуулж, нийт багш, оюутан тав тухтай үйлчлүүлэх өргөн боломж бүрдүүлсэн. ОУХНУС нь дэргэдээ 8000 гаруй ном, сурах бичиг, сэтгүүлтэй, 38 суудалтай уншлагын танхимаар үйлчилж байна.
- ✓ Тэнхимийн хамт олны зүгээс мэргэжлийн хичээлийн сурах бичгээр хангахад ихээхэн анхаарч, өөрсдөө цөөнгүй ном сурах бичиг бичиж, хэвлүүлсний дээр хамтын ажиллагаатай олон улсын байгууллага, их сургуулиуд, гадаадын зөвлөх профессоруудын тусламжтайгаар мэргэжлийн номын сурах бичгийн хангамжийг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлж ирсэн ба сургуулийн зүгээс ном сурах бичиг худалдан авах хөрөнгө оруулалтыг жил тутам тасралтгүй хийж ирсэн.
- ✓ Олон улсад түгээмэл эрдэм шинжилгээний мэдээллийн сангуудын эрхийг авч, ашиглах боломж бүрдүүлсэн.
- ✓ Номын сангийн ашиглалтын хувьд цахим каталог КОНА систем ашиглах боломж бүрдэж, магистрын судалгааны ажлууд 100% цахим хэлбэрт шилжсэн нь суралцагч бүр МУИС-ийн сүлжээнээс шууд ашиглах боломж олгох давуу талтай.
- ✓ Тэнхимийн зүгээс олон улсын хурал, хэлэлцүүлэг зэрэг арга хэмжээний илтгэл, лекцүүдийг эмхэтгэл болгон хэвлүүлдэг, олон улсын индекс бүхий сэтгүүл эрхлэн гаргаж байгаа зэрэг нь судалгаа, сургалтад өргөн ашиглах эх сурвалж болсон сайн талтай.

### ***Анхаарах асуудал:***

- ✓ Эрдэм шинжилгээ, судалгааны зааланд бакалаврын түвшний оюутнууд төдийлөн үйлчлүүлдэггүй, үйлчлүүлэх боломжтой талаарх мэдээллийг хүргэдэггүй. Нээлттэй мэдээллийн санг ашиглах заавар, зөвлөмжөөр “Төрийн удирдлага” хөтөлбөрийн оюутнууд бүрэн хангагдсан ч оюутны хүсэл эрмэлзэл, судалгааны болон гадаад хэлний ур чадвараас шалтгаалж ашиглалт тааруу байдаг;
- ✓ Хөтөлбөрийн онцлогоос шалтгаалж хичээл практикийн материаллаг нөөцийн ангилал, төрөл бусад хөтөлбөртэй харьцуулахад харьцангуй цөөн байдаг ба багш нар хичээлийн заах арга зүй болон хэлбэрээ өөрчилж, түүнд тохирсон сургалтын хэрэглэгдэхүүнийг шинэчлэх талаар анхаарвал зохилтой;

### ***Зөвлөмж:***

- ✓ Сургалтын заавар, удирдамж, зөвлөмжүүдийг нэгтгэн багцалж, мэдээллийн тодорхой байдлыг хангах;
- ✓ Эрдэм шинжилгээ, судалгааны зааланд бакалаврын түвшний оюутнууд үйлчлүүлэх боломжийн талаарх мэдээллийг бүрэн танилцуулдаг байх;
- ✓ Нээлттэй мэдээллийн сан ашиглалтыг сайжруулах;

***Гуравдугаар шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:***

**“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”**



#### **ШАЛГУУР 4: ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

##### **4.1 Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

##### ***Илрэл, нотолгоо:***

- ✓ МУИС-ийн Хөтөлбөрийн хороо нь Эрдмийн зөвлөл, багш, сургалт эрхэлсэн захиргааны ажилтан, ажил олгогчид болон төгсөгчдийн төлөөллөөс бүрддэг. Ажил олгогчдын болон төгсөгчдийн төлөөлөл нь бүрэлдэхүүн сургуулийн Хөтөлбөрийн хороонд орно. Мэргэжлийн тэнхимд Хөтөлбөрийн дэд хороо ажилладаг. Оролцогч талуудын оролцоог хангасан байна.
- ✓ Тэнхимийн хөтөлбөрийн дэд хороо нь тэнхимийн үндсэн багш нараас бүрдэнэ. Хөтөлбөрийн дэд хорооны ахлагч нь тэнхимийн эрхлэгч байна. Хөтөлбөрийн хороод нь тусгайлсан журмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. (ӨҮТ, Хавсралт 4.1)
- ✓ Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж нь тэнхим бөгөөд багш нарын гуравны хоёроос доошгүй хувийн ирцтэйгээр хуралдаж шийдвэр гаргадаг. Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагаанд тэнхим маш чухал үүрэгтэй. Тэнхим хөтөлбөрийн агуулга, хичээлүүдийн агуулга, хэлбэр, багц цагийн хэмжээ, заах арга зүйг тодорхойлох чухал үүрэгтэй байна.

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

##### ***Анхаарах асуудал:***

- ✓ Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагаанд ажил олгогчдын болон төгсөгчдийн төлөөллийн оролцоог тогтвортой, хүртээмжтэй болгоход анхаарах, ялангуяа хөтөлбөрийн шинэчлэлийн үйл явцад оролцуулах механизм бий болгох.

##### ***Зөвлөмж:***

- ✓ Ажил олгогчдын болон төгсөгчдийн төлөөллийг Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах талаар санал санаачилга гаргаж хэрэгжүүлэх.

## **4.2 Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

### **Илрэл, нотолгоо:**

- ✓ Гадаад улсын их сургуулиуд, тухайлбал, ХБНГУ, БНСУ, АНУ, Камбожийн их сургуулиудын Төрийн удирдлага хөтөлбөртэй хамтран ажиллах гэрээтэй бөгөөд голлох хамтын ажиллагааны хэлбэр нь багш, оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлдэг, хамтарсан семинар, эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг зохион байгуулдаг байна.
- ✓ Олон улсын байгууллагууд, тухайлбал, Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Конрад Аденауэрын сан, Сингапурын Темасек сан зэрэг байгууллагатай хамтран төсөл хэрэгжүүлсэн байна.

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

### **Онцлог зүйл, туршлага:**

- ✓ Хамтын ажиллагааг харьцангуй богино хугацаанд маш сайн хөгжүүлсэн;
- ✓ Олон талт хамтын ажиллагааны бодитой үр дүн бий болгосон.
- ✓ Үндэсний хэмжээнд тодорхой асуудлаар онол, практикийн хэлэлцүүлэг зохион байгуулдаг болсон.

### **Анхаарах асуудал:**

- ✓ Дотоодын их сургуулиудын, тэр дундаа ижил мэргэжлийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа сургууль, тэнхим, нэгжтэй хамтран ажиллах тодорхой алхам хийх талаар анхаарах.

### **Зөвлөмж:**

- ✓ Дотоодын их, дээд сургуулиудтай хамтран ажиллах талаар санаачилга гаргах;
- ✓ Сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, хөгжлийг ижил мэргэжлээр сургалт явуулдаг дээд боловсролын сургалтын байгууллагуудын хэмжээнд хамтран хийх санаачилга гаргах.

## **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

### **Илрэл, нотолгоо:**

- ✓ Тэнхимийн хувьд орлогоо бүрдүүлэх үндсэн эх үүсвэр нь сургалтын төлбөр байна. Гэвч орлогыг шууд захиран зарцуулах эрхгүй бөгөөд 1)оюутнуудад үзүүлэх төвлөрсөн үйлчилгээ; 2)сургалтын орчинг сайжруулах; 3)оюутны мэдээллийн үйлчилгээ; 4)оюутны сурах үйл ажиллагаанд шууд холбоотой

сургалтын үйлчилгээ, багш, бусад ажилтны үйл ажиллагааны зардал, дадлага, хичээл практик, эрдэм шинжилгээний хурал семинарын зардлыг нэгдсэн журмаар МУИС-аас санхүүжүүлдэг.

Нийтийн удирдлагын тэнхим жил бүр:

- ✓ Гадаад арга хэмжээний зардал
- ✓ Багш ажилтныг дэмжих үйл ажиллагааны зардал
- ✓ Эрдэм шинжилгээний ажлын зардал
- ✓ Бусад зардал гэсэн 4 бүлгийн хүрээнд тэнхимийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд холбогдох зардлын тооцоог бүрэлдэхүүн сургуулийн захиргаанд гарган өгч, холбогдох санхүүжилтийг авдаг.
- ✓ Нийтийн удирдлагын тэнхимээс сүүлийн 5 жилд сургалтын төлбөрийн орлогод 291.5 – 464.6 сая төгрөг, хэрэгжүүлсэн төслөөс 11.9 – 33.1 сая төгрөгийг МУИС-д төсөвт төвлөрүүлсэн байна.
- ✓ Нийтийн удирдлагын тэнхимийн нэг жилийн зарлагад багшийн хөгжилд зарцуулсан хөрөнгө нь нийт зарлагын дунджаар 4.7 – 11.2 хувийг эзэлж байна. Үүн дээр “Багшид өгсөн урамшуулал”, “Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулж буй төсөв, дэмжлэг”-ийг нэмж тооцвол энэ хувь нь ойролцоогоор 9 – 13.5 хувь болж байна.
- ✓ Тэнхим нь эрдэм шинжилгээний хурал, семинар, хэлэлцүүлгийг санаачлан шууд харилцаатай их сургуулиуд, олон улсын байгууллагуудын санхүүгийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж иржээ. Тухайлбал, жил бүр NUM Leadership Conference эрдэм шинжилгээний хурал, улиралд 1-2 удаа UB Impulse хэлэлцүүлгийг НҮБХХ, КАС, GIZ зэрэг байгууллагын санхүүжилтээр зохион байгуулдаг ажээ.
- ✓ Түүнчлэн тус тэнхимд зочин профессороор ажилласан гаднын их сургуулийн нэр хүндтэй профессорууд, хамтын ажиллагаатай их сургуулиудаас төсөл хэрэгжүүлж, номын фондыг мэргэжлийн ном, сурах бичгээр баяжуулах, анги, танхим тохижуулах зэргээр дэмжлэг үзүүлдэг байна (ӨҮТ, хуудас 51).

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

**Онцлог зүйл, туршлага:**

- ✓ Багшийн хөгжилд тусгайлан анхаарч, тэнхимийн тогтоосон гадаад хамтын ажиллагааны давуу талаа ашиглан багш нарыг хамтарсан хурал зохион байгуулах, судалгаа хийх, ахисан түвшний сургалтад суралцуулах зэргээр хөгжүүлэхэд анхаардаг.

**Анхаарах асуудал:**

- ✓ Багшийн хөгжлийн төлөвлөлтийн талаар тодорхой мэдээлэл хомс

**Зөвлөмж:**

- ✓ Багшийн хөгжлийн бие даасан төлөвлөгөөтэй болох.

#### **4.4 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

##### ***Илрэл, нотолгоо:***

- ✓ Хөтөлбөрийн зах зээлийн тандан судалгааг хөтөлбөрийг нээхийн өмнө хийж, хэрэгцээгээ тодорхойлж байсан. Түүнээс хойш тандан судалгаа хийгээгүй. Маркетингийн идэвхжүүлэлт нь МУИС-ийн элсэлтийн ерөнхий бодлогын хүрээнд тодорхойлогддог. Liberal Art сургалтын хөтөлбөрийн нөлөөгөөр нийгмийн ухааны чиглэлээр элсэн 1 жил суралцсан оюутнуудын дунд танилцах өдөрлөг зохион байгуулдаг. Хөтөлбөрийн агуулга, төгсөгчдийн ажил эрхлэлт, хөрвөх чадварын талаар голчлон танилцуулдаг. Хэвлэмэл байдлаар хөтөлбөрийн танилцуулгыг гаргадаг. Цахим хуудсаар (МУИС-ийн болон ОУХНУС-ийн веб) танилцуулга бэлтгэсэн. Олон улсын эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, мэргэжлийн зөвлөгөөн, мөн теле хэлэлцүүлэг зохион байгуулж сурталчилдаг.
- ✓ “Төрийн удирдлага” хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланд хөндлөнгийн үнэлгээ хийх явцад оюутан, төгсөгч, ажил олгогчидтой хийсэн онлайн ярилцлага хийхэд ихэнх оролцогч хөтөлбөрийн агуулга, арга зүй, үр дүн, онцлогийн талаарх сурталчилгаа дутмаг, цаашид сурталчилгааг олон хэлбэрээр зохион байгуулахыг санал болгож байв.

*Шалгуурыг хангасан байдал: “ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН”*

##### ***Онцлог зүйл, туршлага:***

- ✓ Үндсэн үйл ажиллагаагаар хөтөлбөрийн сурталчилгаа хийдэг.

##### ***Анхаарах асуудал:***

- ✓ Хөтөлбөрийн талаар идэвхжүүлэлтийн хөтөлбөр боловсруулах.

##### ***Зөвлөмж:***

- ✓ Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хадгалахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.
- ✓ Хөтөлбөрийг сурталчлах боломж, арга хэлбэрийг боловсруулах.

#### **4.5 Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

##### ***Илрэл, нотолгоо:***

- ✓ МУИС-ийн болон ОУХНУС-ийн цахим хуудас, Удирдлагын мэдээллийн Сиси системээр дамжуулан хөтөлбөрийн агуулга, хэрэгжилт болон тэнхимийн үйл ажиллагааны талаар мэдээлэл түгээдэг. Мөн тэнхимийн мэдээллийн самбараар дамжуулан мэдээлэл түгээдэг.

- ✓ Оюутнуудын ангийн хурал, нийгмийн сүлжээгээр мэдээлэл мөн дамжуулна. Багш нар улирал тутамд нээлттэй хичээл зохион байгуулдаг. БНСУ-ын Хансунг Их сургуультай хамтран онол, арга зүйн сэтгүүл гаргадаг.
- ✓ Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь олон улсын хамтын ажиллагаагаа бие даан хөгжүүлж, олон улсын байгууллага, гадаад улс орны (БНСУ, ХБНГУ гэх мэт) их сургуулиудтай хамтран эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах, мэргэжлийн сэтгүүл эрхлэн гаргах зэргээр өөрийн үйл ажиллагаагаа сурталчлах, үүгээр дамжуулан мэдээлэл идэвхтэй түгээх ажлыг хийдэг байна. Түүнчлэн хамтарсан хурал, хэлэлцүүлгийн явцад ТВ, сонин, сэтгүүл болон бусад мэдээллийн хэрэгслээр ярилцлага өгөх, нэвтрүүлэг бэлтгэн хэрэгжүүлэх зэргээр мэдээллийг түгээдэг байна. Үүнээс харахад тус тэнхим, хөтөлбөрийн үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй байгаа юм.

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

***Онцлог зүйл, туршлага:***

- ✓ Олон улсын хамтарсан онол, арга зүйн сэтгүүл эрхлэн гаргадаг.

***Анхаарах асуудал:***

- ✓ Элсэгчдэд болон төгсөгчдөд зориулсан төрөлжсөн мэдээлэлтэй байх

***Зөвлөмж:***

- ✓ Төгсөгчдөд зориулсан эргэх холбоог нэмэгдүүлж, төгсөгчдийн холбоог бэхжүүлэх

***Дөрөвдүгээр шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:***

**“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”**

## **ШАЛГУУР 5. СУРАЛЦАГЧДАД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

### **5.1 Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

#### **Илрэл, нотолгоо:**

- ✓ Төрийн удирдлага хөтөлбөрт оюутан элсүүлэх үйл ажиллагаа их сургуулийн хэмжээнд нэгдсэн бодлого, зохион байгуулалтаар БСШУСЯ болон МУИС-ийн дүрэм журмын дагуу явагддаг.
- ✓ МУИС нь Элсэлт, бүртгэлийн хэлтэстэй бөгөөд энэхүү нэгж нь элсэлтийн үйл ажиллагааг их сургуулийн хэмжээнд хариуцаж, элсэлт, шинэ элсэгчдийн хичээл сонголт, үнэлгээ, дүнгийн талаарх санал гомдол, шилжилт хөдөлгөөн, чөлөө олгох, эргэн суралцах, төгсөх зэрэгт холбогдох мэдээлэл зөвлөгөө өгч ажилладаг.
- ✓ Шинээр элсэгчдэд зориулсан чиглүүлэх сургалтыг МУИС-ийн календарьчилсан төлөвлөгөөний дагуу Элсэлт, бүртгэлийн хэлтэс, Ахисан түвшний сургуулийн бодлогын газар, Мэдээллийн технологийн газар, Оюутан төгсөгчийн хэлтэс, Номын сан, Хөтөлбөр чанарын баталгаажуулалтын хэлтэс зэрэг нэгж хамтран хичээлийн жилийн эхэнд тогтмол зохион байгуулдаг.
- ✓ МУИС-ийн хувьд элсэгчдэд зориулсан чиглүүлэх сургалтын календарьчилсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг бөгөөд сургууль, тэнхимийн танилцуулга, элсэгчдэд зориулсан гарын авлага, брошур зэрэг мэдээлллийг гаргадаг. (Өөрийн үнэлгээний тайлан болон МУИС-ийн веб хуудас, интернэтийн мэдээлэл)
- ✓ “Төрийн удирдлага” хөтөлбөрийн шинээр элсэгчид нь МУИС-ийн нэгдүгээр түвшний оюутнууд байдаг (элссэн оныхоо хаврын улиралд мэргэжлээ сонгодог) ба тэдэнд зориулан НУТ-ийн зүгээс нэгдсэн уулзалт зохион байгуулж, “Төрийн удирдлага” хөтөлбөрийн зорилго, эзэмших мэдлэг, ур чадвар, мэргэжлийн хичээлүүдийн уялдаа, залгамж холбоо, шаардагдах ном сурах бичиг, сургууль, тэнхимээс оюутнуудын дунд зохион байгуулдаг арга хэмжээ зэргийн талаар танилцуулдаг;
- ✓ НУТ-ийн зүгээс шинээр элсэгчдийн Нийгмийн тухай мэдлэг хичээлийн оноог 30%-аар тооцож элсэлтийн оноог гаргаж байгаа нь нийтийн удирдлагын шинжлэх ухааны суурь мэдлэгтэй сурагчдын элсэх боломжийг хязгаарлаж байна хэмээн үзэж МУИС-ийн захирлын 2019 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн А/290 дүгээр тушаалын дагуу Элсэлтийн бүртгэлийн хэлтсээс “Журамд санал авах тухай” албан бичгийн хариуд Төрийн удирдлага хөтөлбөрийн онцлогийг харгалзан үзэж “Нийгмийн тухай мэдлэг” хичээлийг суурь шалгалтад тооцох саналыг хүргүүлжээ.

- ✓ Төрийн удирдлага хөтөлбөрт элсэгчдийн ЕШ-ын дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцааны талаарх мэдээллээс үзэхэд хөтөлбөрт элсэн суралцагчдын тоо сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байна. (Өөрийн үнэлгээний тайлан, Хуудас. 58- 59)
- ✓ Оюутнууд болон төгсөгчид, ажил олгогчдын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас үзэхэд хөтөлбөрт элсэн суралцахад хүндрэлтэй зүйл байхгүй бөгөөд тухайн хөтөлбөрөөр элсэн суралцаж байгаа болон төгссөндөө сэтгэл ханамжтай байдаг байна.

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

**Онцлог зүйл, туршлага:**

- ✓ Нийтийн удирдлагын тэнхим нь Төрийн удирдлага хөтөлбөрт оюутнуудыг элсүүлэн суралцуулах талаар багагүй чармайлт гаргаж ажилладаг ба тэнхимийн зүгээс олон улсын шинжтэй болон дотоодын олон тооны арга хэмжээ зохион байгуулж, тэдгээрт оюутнуудаа сайтар татан оролцуулдаг нь хөтөлбөрийг нийтэд таниулах, нэр хүндийг өргөх, улмаар хөтөлбөрт элсэгчдийг татахад томоохон түлхэц болох талтай.

**Анхаарах асуудал:**

- ✓ Хөтөлбөрт элсэгчдийн тоо сүүлийн жилүүдэд жил тутам багасаж ирсэн. (Энэ талаар суралцагчид, төгсөгчидтэй хийсэн ярилцлагын үеэр сул тал болж олонтаа дурдагдаж байсныг тэмдэглэе.)
- ✓ Хөтөлбөрийн талаар элсэгчдэд зориулсан мэдээлэл сурталчилгаа дутмаг байгааг анхаарах.

**Зөвлөмж:**

- ✓ Хөтөлбөрийн элсэлтийн хяналтын тооноос бодит элсэлт жил тутам бага байж ирсэнд дүгнэлт хийж, элсэгчдийн тоог нэмэгдүүлэх талаар сургууль, тэнхимийн зүгээс анхаарч ажиллах;
- ✓ Тухайн хөтөлбөрийн талаар элсэгчдэд зориулсан мэдээлэл сурталчилгааг өргөжүүлэх, маркетинг идэвхжүүлэлтийг сайжруулах талаар хөтөлбөр хариуцсан нэгж, ялангуяа МУИС болон бүрэлдэхүүн сургууль (ОУХНУС)-ийн зүгээс илүү анхаарч ажиллах, энэ чиглэлээр бодитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- ✓ Хөтөлбөрт шинээр элсэгчдээс тухайн мэргэжлийг сонгосон шалтгаан, хүлээлт, ерөнхий мэдлэг, чадвар зэргийн талаар санал асуулгын судалгаа авч байх нь нэг талаас, тэдний хэрэгцээ шаардлагыг илүү гүнзгий таних, нөгөө талаар, хөтөлбөрийг төгсөхдөө оюутан хэр зэрэг хөгжиж төлөвшсөн, сэтгэл ханамж ямар түвшинд байгааг мэдэх боломж олгоно гэдгийг анхаарч, хэрэгжүүлж, тогтмолжуулах (сургалтын хөтөлбөрийн олон улсын магадлан итгэмжлэлээр энэ хэлбэрийн судалгаа нь хөтөлбөрийн үр дүнгийн үнэлгээний нэг чухал аргад тооцогддог).

## 5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

### **Илрэл, нотолгоо:**

- ✓ НУТ нь оюутанд зөвлөн туслах үйлчилгээний ажлын төлөвлөгөө гаргаж мөрдөж ажилладаг (Тэнхимийн төлөвлөгөө, тайлангийн мэдээлэл, Өөрийн үнэлгээний тайлан: Хуудас. 60-64, Хүснэгт 5.3, Хавсралт 5.1).
- ✓ Түүнээс гадна, МУИС, түүний холбогдох хэлтэс албад болон мэргэжлийн сургууль, тэнхимийн зүгээс оюутны зөвлөх туслах үйлчилгээг үзүүлдэг ба оюутнуудыг элсэлт, сургалт, төгсөлт болон нийгмийн үйлчилгээний талаарх мэдээллээр хангаж ажилладаг. Тухайлбал:
  - **МУИС** – Сургалтын байр, анги танхим, техник хэрэгсэл, номын сан, лаборатори, интернет, оюутны байр, хоол хүнс, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг оюутны суралцах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлж ажиллах үүрэгтэй. Түүнчлэн, олон улсын болон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцсон оюутанд дэмжлэг, урамшуулал олгох, гадаад ба дотоодын сургалтын тэтгэлэг, эрүүл мэндийн даатгалд хамруулах, орон нутгийн оюутнуудад замын зардал олгох зэрэг нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлдэг.
  - **Элсэлт, бүртгэлийн хэлтэс**- элсэлт, хичээл сонголт, үнэлгээ, шилжилт, чөлөө олгох, эргэн суралцах, төгсөлт зэрэгтэй холбогдох мэдээлэл зөвлөгөө өгч ажилладаг.
  - **Оюутан төгсөгчийн хэлтэс**: оюутны тэтгэлэг, санхүүгийн дэмжлэг, тэтгэлэг, боловсролын зээлийн сангийн үйлчилгээ, буцалтгүй тусламж, оюутан солилцоо, хууль эрх зүйн зөвлөх үйлчилгээ, дотуур байр, эрүүл мэнд зэрэг оюутны үйлчилгээний талаар чиглүүлэн танилцуулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулдаг.
  - **Мэдээллийн технологийн газар**: Сиси сургалтын систем, хэрэглээний талаар мэдээлэл зөвлөгөө өгдөг.
  - **Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс** Сургалтын хөтөлбөр, мэргэжил сонголт, хос хавсарга хөтөлбөрийн талаарх мэдээлэл өгдөг.
  - **Номын сан**- номын сангийн үйлчилгээ, түүнд тавигдах шаардлага, номын сангийн үнэмлэх захиалга зэрэгтэй холбоотой мэдээлэл зөвлөгөө өгч ажилладаг.
- ✓ **Хууль зүйн зөвлөгөө**: МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах ангийн оюутнууд “Хууль зүйн зөвлөгөө өгөх төв” болон [www.Mongolianlaws.com](http://www.Mongolianlaws.com) цахим хуудсаар дэмжуулан оюутнуудад үнэ төлбөргүй зөвлөгөө өгдөг.
- ✓ **Сэтгэл зүйн зөвлөгөө** өгөх үйлчилгээг оюутнуудад “Сэтгэл зүйн тэнхим”-ийн ахлах ангийн оюутнууд сайн дурын клуб, бүлгээр дамжуулан үзүүлдэг.
- ✓ **Оюутны дотуур байр**: МУИС нь нийт 1394 оюутан байрлах хүчин чадалтай 5 дотуур байраар оюутнууддаа үйлчилдэг.
- ✓ **Оюутны эрүүл мэндийн үйлчилгээ**: МУИС-ийн “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх төв” –суралцагчдад аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх,



амьдралын зөв хэвшил эзэмшүүлэхэд зөвлөх, чиглүүлэх эрүүл мэндийн үзлэг хийх, вакцинжуулах үйлчилгээ үзүүлдэг;

- ✓ **Хоолны үйлчилгээ:** Хөтөлбөрийн оюутнууд МУИС-ийн хичээлийн IV байр-Бизнесийн сургуулийн цайны газраар гол төлөв үйлчлүүлдэг. Төрийн удирдлага хөтөлбөрийн сургалт явагддаг гол байр болох ОУХНУС-ийн байранд хоол, цайны газар байхгүй;
- ✓ **Тэнхимийн үйлчилгээ:** НУТ нь оюутанд чиглэсэн болон хамтын ажиллагааны хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан, мөрдөж ажилладаг ба тэнхимийн зүгээс оюутнуудад мэргэжлийн ангийн зөвлөх багш, судалгааны ажлын удирдагч томилон сургалт, эрдэм шинжилгээний зөвлөн туслах үйлчилгээг үзүүлдэг. Мөн мэргэжлийн ангийн дарга нарыг сонгон ажиллуулдаг ба тэдгээр нь тэнхим болон бусад нэгжийн мэдээллийг дамжуулах, соёл, спортын арга хэмжээнд оюутнуудыг зохион байгуулж, идэвхтэй оролцуулах, мөн танилцах уулзалт, аялал болон чөлөөт цагийн хөтөлбөрийг зохион байгуулах, мэдээлэл хүргэх зэрэг ажлуудыг хариуцдаг. Түүнчлэн, тэнхимийн сургалтын туслах ажилтан оюутнуудад тусалж зөвлөх чиглүүлэх үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Нийтийн удирдлагын тэнхимийн “Мини Парламент” клуб нь Төрийн удирдлагын мэргэжлийн оюутнуудаас сонгон шалгаруулах замаар гишүүдээ бүрдүүлж, бүтэц зохион байгуулалт, удирдлагаар хангадаг оюутны сайн дурын клуб бөгөөд гишүүд, мэргэжлийн болон бусад мэргэжлийн оюутнуудад зориулсан олон талт арга хэмжээг зохион байгуулж, оюутнуудыг өргөнөөр хамруулж ирсэн.Тэнхимийн үйл ажиллагаа, төлөвлөгөө, хичээл сургалт, эрдэм шинжилгээ, олон нийтийн арга хэмжээ, профессор, багш нарын оюутанд зөвлөх цагийн хуваарь г.м.-ийн талаарх зарлал мэдээллийг оюутнуудад түргэн шуурхай хүргэх зорилгоор мэдээллийн самбар ажиллуулдаг.
- ✓ Сургууль, тэнхимийн зүгээс байгууллага, хөтөлбөрийн танилцуулга, оюутнуудад зориулсан гарын авлага, брошур, мэдээллийн самбар, вэбсайт зэргээр дамжуулан оюутан, суралцагчдыг шаардлагатай мэдээллээр хангаж ажилладаг;
- ✓ Тэнхимийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлангаас үзэхэд Оюутны сургалт, ЭШ, нийгмийн үйл ажиллагаа, Оюутанд зөвлөн туслах үйл ажиллагааны талаарх мэдээллүүдийг нэгтгэн цэгцэлж хөтөлдөг. (НУТ-ийн Оюутан, Төгсөгчдийн талаарх мэдээллийн хавтас, Өөрийн үнэлгээний тайлан, Хуудас. 60-64, г.м.)

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

**Онцлог зүйл, туршлага:**

- ✓ НУТ-ийн дэргэд оюутны “Мини Парламент” клуб ажиллуулж, гишүүд, мэргэжлийн болон бусад мэргэжлийн оюутнуудад зориулсан олон талт арга хэмжээг зохион байгуулж, оюутнуудыг өргөнөөр хамруулж ирсэн нь сайн туршлага болох талтай.

### **Анхаарах асуудал:**

- ✓ Оюутны зөвлөн туслах үйлчилгээ, чиглүүлэх сургалтын үр дүнг тооцсон судалгаа, нотолгоо дутмаг;
- ✓ Оюутнуудыг эрдэм шинжилгээ, судалгааны ажилд аль болох өргөнөөр оролцуулах, үр өгөөжийг дээшлүүлэх;
- ✓ Оюутны үйлчилгээний төрлүүдээр сэтгэл ханамжийн судалгаа авч үнэлгээ гаргасан байдал дутмаг (холбогдох хэлтэс албадын үйл ажиллагаа, дотуур байр, хоол, цайны газар, эрүүл мэндийн үйлчилгээ г.м.)

### **Зөвлөмж:**

- ✓ Оюутны зөвлөн туслах үйлчилгээ, чиглүүлэх сургалтын үр дүнг гаргаж, тооцоо судалгааг тогтмолжуулах;
- ✓ Оюутнуудыг эрдэм шинжилгээ, судалгааны ажилд аль болох өргөнөөр оролцуулах, үр өгөөжийг дээшлүүлэх;
- ✓ Оюутны үйлчилгээний төрөл (холбогдох хэлтэс албадын үйл ажиллагаа, дотуур байр, хоол, цайны газар, эрүүл мэндийн үйлчилгээ г.м.)-ээр сэтгэл ханамжийн судалгаа авч, үнэлгээ гаргахад анхаарч ажиллах;

## **5.2 Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

### **Илрэл, нотолгоо:**

- ✓ МУИС, ОУХНУС-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Сургах ба суралцах үйл явцыг дэлхийн тэргүүлэх түвшинд хүргэх чиглэлийн хүрээнд суралцагчдад төлөвших, хөгжих, авьяас илрүүлэх, ажил амьдралын дадал, чадвар эзэмших боломжийг олгох, нэмэлт үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх” зорилт дэвшүүлж, оюутанд чиглэсэн үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, клубийн үйл ажиллагааг дэмжихээр заасан байна (МУИС, ОУХНУС-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Өөрийн үнэлгээний тайлан).
- ✓ НУТ-ийн дэргэд оюутнуудыг сургаж, хөгжүүлэх, чадваржуулах, олон нийтийн оролцоог хангах, өрсөлдөх чадвартай манлайлагч залуусыг бэлтгэхэд нөлөөлөх зорилгоор “Мини Парламент” клубийг 2015 оноос эхлэн байгуулж ажиллуулсан. Одоогийн байдлаар клубийн үйл ажиллагаанд байнгын гишүүнчлэлтэй 26 оюутан, байнгын бус 100 гаруй оюутнууд тогтмол оролцож байна (Өөрийн үнэлгээний тайлан: Хуудас. 64, Хавсралт 5.1, Тэнхимийн төлөвлөгөө, тайлан).
- ✓ Оюутны клубийн үйл ажиллагаанд сургуулийн зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлдэг бөгөөд тухайлбал, “Мини Парламент” клубийн үйл ажиллагаанд 2014-2015 оны хичээлийн жилд 300.0 мян. төг.-ний санхүүжилт олгож байсан бол 2018-2019 онд энэ нь 1300.0 мян. төг.-д хүрсэн байна (Өөрийн үнэлгээний тайлан: Хуудас. 64).
- ✓ Тус клубээс зохион байгуулдаг “Төрийн албан хаагчийн загвар шалгалт”, “NUM PARLIAMENT оюутны загвар хуралдаан” зэрэг нь бүтэц, агуулгын хувьд төрийн албаны онцлог, зохион байгуулалт, чиг үүрэгтэй уялддагийн зэрэгцээгээр олон

төрлийн сайн дурын ажил зохион явуулдаг нь оюутнуудад туршлага хуримтлуулах боломж олгож байна.

- ✓ МУИС-ийн хэмжээнд оюутны сайн дурын ажлыг үнэлэх эрх зүйн зохицуулалт одоогоор бүрдээгүй боловч НУТ-ийн зүгээс өөрийн зохион байгуулдаг “NUM LEADERSHIP CONFERENCE”, “UB UMPULSE” зэрэг олон улсын хурлуудын зохион байгуулалтын ажилд оролцсон оюутнуудад англи, монгол хэлээр сертификат олгодог.
- ✓ Оюутны сайн дурын ажил, нийгмийн оролцоо нь “Шилдэг оюутан” болон тэтгэлэгт хөтөлбөрийн шалгаруулалтын нэг чухал шаардлага болдог бөгөөд хөтөлбөрийн оюутнуудын хувьд амжилт гаргах нэг үндэслэл болж ирсэн ба дотоодын тэтгэлэгт хөтөлбөрүүдэд хамрагдсан нийт оюутнуудын 52.2% нь “Мини Парламент” клубийн гишүүд байна.
- ✓ Түүнчлэн хөтөлбөрийн оюутнууд суралцах хугацаанд дээр дурдсан клуб болон тэнхимээс зохион байгуулж ирсэн олон улсын болон үндэсний хэмжээний ЭШ-ний хурал, семинар, сургалт, хэлэлцүүлгүүд, олимпиад, уралдаан тэмцээнд оролцож, нийгмийн оролцоо сайтай байсан нь ажилд орох нэг хүчин зүйл болдог ба үүний ач холбогдлын талаар оюутан, төгсөгч, ажил олгогчдын ярилцлагаар цөөнгүй дурдагдаж байсныг тэмдэглэх нь зүйтэй (Оюутан, төгсөгч, ажил олгогчдын ярилцлага);
- ✓ МУИС-ийн хэмжээнд Оюутан төгсөгчийн хэлтэс Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг хариуцдаг бөгөөд 1-4 түвшний оюутнуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулах, цагийн болон байнгын ажлын байранд зуучлах үйлчилгээ үзүүлэх, карьераа хөгжүүлэх, нээх чиглэлээр сургалт – зөвлөгөө өгөх, дадлага, интерншип хөтөлбөрийг хэрэгжүүлдэг нь сайшаалтай. Үүний үр дүнд 24 оюутныг байнгын, 58 оюутныг түр ажлын байранд, 80 оюутныг цагийн ажилд, 144 оюутныг МУИС-ийн түр ба цагийн ажилд, 8 оюутныг интерншип хөтөлбөрт тус тус зуучилсан ба эдгээрийн дотор Төрийн удирдлагын оюутнууд ч бас хамрагдсан байна.
- ✓ Түүнчлэн, хөтөлбөрийн цөөнгүй оюутан МУИС болон бусад байгууллагаас зарлагдсан тэтгэлэгт хөтөлбөрүүд, Боловсролын зээлийн сангийн болон Оюутны хөгжлийн зээл, Буцалтгүй тусламж зэрэгт хамрагдсан байна. (Өөрийн үнэлгээний тайлан: Хавсралт 5.4-5.6, Газар дээр танилцсан Тэнхимийн төлөвлөгөө, тайлан)

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

**Онцлог зүйл, туршлага:**

- ✓ Тэнхимийн дэргэд байгуулагдан үйл ажиллагаа явуулж ирсэн “Мини Парламент” клуб болон олон улсын арга хэмжээ, мэргэжлийн хэлэлцүүлгүүд нь хөтөлбөрийн оюутнуудыг сургаж, хөгжүүлэх, чадваржуулах, салбарын мэргэжилтнүүдтэй танилцах, олон нийтийн ажлын туршлага хуримтлуулахад чухал үүрэг гүйцэтгэж байна.
- ✓ Сургуулийн зүгээс оюутнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулах, цагийн болон байнгын ажлын байранд зуучлах үйлчилгээ үзүүлэх, карьераа хөгжүүлэх, нээх

чиглэлээр сургалт–зөвлөгөө өгөх, дадлага, интерншип хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай юм.

#### **Анхаарах асуудал:**

- ✓ МУИС-ийн хувьд оюутны сайн дурын ажлыг үнэлэх тогтолцоо хараахан бүрдээгүй, сургууль, нэгдсэн зохицуулалт одоогоор байхгүй байна.
- ✓ Судлаач оюутан клубийн үйл ажиллагаа хараахан тогтворжоогүй байгаа бөгөөд оюутны сайн дурын клуб ажиллуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхэд тэнхимээс судалгааны арга зүйн дэмжлэг үзүүлэхэд анхаарах;

#### **Зөвлөмж:**

- ✓ Оюутны сайн дурын ажлыг үнэлэх тогтолцоо, нэгдсэн зохицуулалт бий болгоход анхаарах;
- ✓ Оюутны сайн дурын клубүүдийн үйл ажиллагааг эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг чиглэлээр идэвхжүүлэх, энэ тал дээр тэнхимийн зүгээс арга зүйн дэмжлэг үзүүлэх;

### **5.3 Суралцагчийн шилжилт хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

#### **Илрэл, нотолгоо:**

- ✓ Тус сургуулийн хувьд оюутны шилжилт хөдөлгөөнийг зохицуулахдаа “Монгол улсын их сургуульд оюутан шилжүүлэн суралцуулах тухай журам” (МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2017 оны 12 сарын 28-ны өдрийн А/49 тоот тушаалаар батлагдсан ба 2019 онд шинэчлэгдсэн)-ыг дагаж мөрддөг.
- ✓ Дээрх журмын дагуу оюутны шилжилтийн бүртгэлийг хичээлийн жилд хоёр удаа (намрын улиралд 7 сарын 01-ээс 08 сарын 15-ныг дуустал, хаврын улиралд 12 сарын 15-наас 01 сарын 15-ныг дуустал) <https://burtgel.num.edu.mn/> бүртгэлийн нэгдсэн системээр хийдэг ба шилжин суралцахыг хүсэж буй хөтөлбөрийн шаардлагын дагуу шалгалт өгч, нийт онооны 60-аас доошгүй хувийг авсан шалгуулагчдыг оноогоор жагсааж, хяналтын тоонд багтаан элсүүлнэ. Шалгалтын оноо тэнцсэн тохиолдолд өмнө суралцсан сургуулийн голч дүнг харгалзах заалтыг харгалздаг байна.
- ✓ Шилжихийг хүсэгч хэд хэдэн хөтөлбөрт бүртгүүлж, шалгуулж болох ч МУИС-ийн зөвхөн нэг хөтөлбөрт шилжин суралцах эрхтэй байдаг.
- ✓ МУИС-д оюутан шилжүүлэн суралцуулах тухай журам 10-р зүйлд зааснаар шилжин суралцагчийн өмнө үзсэн мэргэжлийн хичээлийн багц цаг дүйцүүлэлтийг бүрэлдэхүүн/салбар сургуулийн мэргэжлийн тэнхим, ерөнхий суурь хичээлийн багц цагийн дүйцүүлэлтийг Элсэлт, бүртгэл хариуцсан нэгж хийж, шилжүүлэн суралцуулахыг МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулж байна.
- ✓ Бакалаврын түвшний өмнө судалсан хичээлүүдийн багц цагаас 45 хүртэлх багц цагийг шилжүүлэн тооцож болох ба МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжих

тохиолдолд хөтөлбөрүүдийн ижил төстэй байдлаас хамааран дүйцүүлэх багц цаг нь 75 хүртэл байж болдог.

- ✓ Шилжин суралцагчийн үзэж судалсан тухайн хичээлийн багц цаг нь МУИС-ийн харгалзах хичээлийн багц цагт хүрэхгүй, мөн залгамж холбоотой хичээлийг судлаагүй бол шилжүүлэн тооцохгүй. Багц цагийн дутууг харгалзах цагийн хэмжээгээр нэмж судлах зэргээр нөхөн гүйцээх боломжгүй. Илүү байгаа тохиолдолд МУИС-д баримталж байгаа тухайн хичээлийн багц цагаар тооцож шилжүүлнэ. Хэрэв тухайн сургуулийн багц цагийн тодорхойлолт МУИС-аас өөр буюу сургалтын агуулгыг цагаар тооцдог бол МУИС-ийн Сургалтын журамд зааснаар шилжүүлэн тооцохоор журамлажээ.
- ✓ Төрийн удирдлага хөтөлбөрийн тухайд 2015-2019 оны намрын улирал хүртэлх хугацаанд шилжин ирэгсдийн багц цагийг дүйцүүлэлтийн судалгаанаас үзэхэд дундаж дүйцүүлсэн багц цаг 2015-2016 оны намрын улиралд хамгийн бага буюу 30 кредит, 2018-2019 оны хаврын улиралд хамгийн их буюу 53 кредит цаг байсан байна. Өөрийн үнэлгээний тайлан, Шилжсэн суралцагчдын багц цаг дүйцүүлэлтийн тоон мэдээлэл (Хүснэгт 5. 1);
- ✓ Мэргэжлийн тэнхимийн хувьд “Төрийн удирдлага” хөтөлбөрт шилжин суралцагчдад тавигдах шаардлага (Мэдлэг /ЭШ-ын оноо, голч дүн/, Чадвар /сонирхол, хобби/, Хандлага /ТУ хөтөлбөрийн чиглэлээр цаашид ажиллах сонирхол, ТАХ-ын ёс зүй зэрэг)-ыг тодорхойлж, түүний дагуу шилжүүлэн суралцуулж байна.
- ✓ Төрийн удирдлага хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудын элсэлт болон шилжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд МУИС болон бусад сургуулиас шилжин ирж суралцаж байгаа оюутнуудын тоо нь хөтөлбөр сонголтоор элсэн суралцаж байгаа оюутнуудаас илүү хувьтай байна. Энэ нь уг мэргэжлийн элсэлтийн квот тухайн газар орон нутагт цөөн байснаас хуваарь авч чадалгүй өөр хөтөлбөр сонгосонтой холбоотой. Дээрхээс дүгнэхэд тус сургуулийн хэмжээнд оюутны шилжилт хөдөлгөөн нэгдсэн журмаар зохицуулагдаж, хэвшсэн байна.

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

#### **Онцлог зүйл, туршлага:**

- ✓ МУИС-ийн хэмжээнд оюутны шилжилт хөдөлгөөнийг холбогдох журмын дагуу нэгдсэн байдлаар зохицуулдаг, үйл ажиллагаа тогтворжиж уламжлал болоод байгаа нь оюутан, суралцагчдын хувьд хүндрэлгүй, тэгш, нээлттэй үйлчлэх боломж олгож байна.

#### **5.4 Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна
---

### ***Илрэл нотолгоо:***

- ✓ МУИС-ийн хэмжээнд төгсөгчдөд тавигдах шаардлага, төгсөх, төгсөлтийн баримт бичиг олгох үйл ажиллагааг 2015 оны А/203 дугаар МУИС-ийн захирлын тушаалаар батлагдсан “МУИС-ийн сургалтын журам”-аар зохицуулдаг.
- ✓ Сургалтын хөтөлбөрийг амжилттай дүүргэсэн суралцагчдад МУИС-ийн сургалтын журмын 4.12.2-т заасан төгсөгчдөд тавигдах шаардлагын дагуу төгсөлтийн баримт бичиг (Бакалаврын зэргийн диплом, энгэрийн тэмдэг) -ийг Төгсөлтийн салбар комиссын шийдвэрийг үндэслэн, МУИС-ийн захирлын тушаалаар олгодог.
- ✓ Бакалаврын зэргийн диплом нь МУИС-ийн Удирдах зөвлөлийн дарга, МУИС-ийн захирал, төгсөлтийн ерөнхий комиссын дарга, бүрэлдэхүүн сургуулийн захирлын гарын үсэг, МУИС-ийн тамга тэмдгээр баталгаажих ба дугаар, бүртгэлийн дугаартай байна. Түүнчлэн, бакалаврын оюутан суралцах хугацаандаа судалбал зохих хичээлийг бүрэн судалсан, 1.8-аас дээш голч дүнтэй оюутанд МУИС-ийн тухайн мэргэжлийн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд заагдсан бүх хичээл судалсныг гэрчилсэн тусгай баримт бичиг олгох журамтай.
- ✓ Төгсөх үйл явцын хувьд суралцагч журамд заасны дагуу төгсөх хүсэлтээ өгч, сургалтын албаар төгсөх шаардлагад нийцсэн эсэхээ баталгаажуулж, судалгааны ажил бичсэн тохиолдолд суралцагч судалгааны ажлаа хамгаалан, төгсөлтийн салбар комиссын хурлын шийдвэр, Хамгаалуулах зөвлөлийн хуралдааны протокол, тогтоолоор төгсөх бол судалгааны ажил бичээгүй суралцагч суралцсан хугацааны тодорхойлолтоор, төгсөлтийн салбар комиссын хурлын шийдвэрээр төгсөх боломжтой байдаг.
- ✓ МУИС-ийн оюутны төгсөлтийн баримт бичиг боловсруулахдаа Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын А/480 дугаар тушаалаар “Дээд боловсролын диплом олгох журам”-ыг үндэс болгосон байна.
- ✓ МУИС-ийн хэмжээнд оюутны төгсөлт, төгсөлтийн баримт бичиг олгох үйл ажиллагаа МУИС-ийн захирлын тушаалаар батлагдсан нэгдсэн журмаар зохицуулагдаж, хэвшсэн.
- ✓ МУИС-ийн төгсөлтийн үйл ажиллагаа болон төгсөлтийн баримт бичиг нь Монгол улсын Дээд боловсролын тухай хууль, Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын тушаал шийдвэрт бүрэн нийцсэн байна.

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

***Тавдугаар шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:***

**“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”**

## **ШАЛГУУР 6. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

### **6.1 Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

#### **Илрэл, нотолгоо:**

- ✓ МУИС нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүний нөөцийн бодлоготой, багшийн сонгон шалгаруулалтын нэгдсэн журамтай бөгөөд эдгээрийг Монгол улсын Дээд боловсролын салбарын эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан боловсруулж, мөрдөж байна. Тухайлбал, Дээд боловсролын тухай хуулиар багшид тавигдах шаардлагыг тогтоосон байдаг (13.1 Их сургууль, дээд сургууль, коллежид мэргэжлийн хичээлийг магистр, түүнээс дээш зэрэгтэй багш заах бөгөөд магистр, докторын хөтөлбөрийн хичээлийг докторын зэрэгтэй багш заана; 13.2. Их сургууль, дээд сургууль, коллежийн багшийн мэргэжил эзэмшээгүй орон тооны багш заах арга зүй эзэмшсэн байна).
- ✓ МУИС-ийн 2016-2024 оны стратеги төлөвлөгөөнд “Багшлах шилдэг боловсон хүчнийг бүрдүүлэх” зорилтыг дэвшүүлсэн ба энэ хүрээнд “Шилдэг эрдэмтэн багшийг сонгох, ажиллуулах, ажлыг нь үнэлэх, хадгалах тогтолцоог нэвтрүүлэх” стратегийн хэрэгжүүлэхээр заасан;
- ✓ Түүнчлэн, ОУХНУС-ийн стратеги төлөвлөгөөнд “Эрдмийн зэрэг цолтой багш нарын тоо нийт багш нарын 70%-аас доошгүй байх зорилтыг үндэслэн тэнхимд одоо ажиллаж буй багш нар докторын зэрэг хамгаалахад дэмжих, докторын зэрэгтэй багшийг шинээр ажилд авахаар заасан (ОУХНУС-ийн стратеги төлөвлөгөө);
- ✓ Хөтөлбөрүүдэд багшийг сонгон шалгаруулж авахдаа МУИС-д профессор, багш ажиллуулах журмын дагуу профессор, багшид тавигдах шаардлага, шинээр багш авах, зөвлөх, гэрээт ба зочин профессор, цагийн багшаар ажиллуулах заалтуудыг баримталдаг (МУИС-д профессор, багш ажиллуулах журам, МУИС-ийн Захирлын 2019.05.06-ны №А/208 тоот тушаалаар шинэчилэн батлагдсан);
- ✓ Сонгон шалгаруулалтад тэнцсэн багштай МУИС-ийн Хөдөлмөрийн дотоод журмын дагуу гэрээ байгуулдаг (МУИС-ийн захирлын 2016 оны 12-р сарын 28-ны өдрийн А/354 дугаар тоот тушаал);
- ✓ Төрийн удирдлага хөтөлбөрт, 2015 оноос хойш шинээр 4 багшийг дээрх журмын дагуу сонгон шалгаруулан авч ажиллуулж байна (Тухайлбал, 2015-2016 оны хичээлийн жилд МРА Г.Мягмар, 2016-2017 оны хичээлийн жилд МВА С.Ариунбилэг, 2018-2019 оны хичээлийн жилд доктор Б.Болормаа, 2019-2020 оны хичээлийн жилд МРА Т.Ганчимэг нар).

- ✓ Нийтийн удирдлагын тэнхимд 2019 оны байдлаар нийт 9 багш ажиллаж байгаа ба энэ нь МУИС-д профессор багш ажиллуулах журмын дагуу албан тушаалын зэрэглэлийн шаардлагыг хангасны дээр доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин 2019-2020 оны хичээлийн жилийн байдлаар 56%-тай байгаа нь сургуулийн хэмжээнд харьцангуй өндөр үзүүлэлт болж байна.
- ✓ МУИС-ийн стратеги төлөвлөгөөнд тусгасан тэргүүлэх чиглэлийн хүрээнд оюутан багшийн тооны харьцаа 2014-2015 онд нэг багшид 25 оюутан, 2018 онд нэг багшид 22 оюутан ногдож байсан бол 2021 онд нэг багшид 18 оюутан, 2024 онд нэг багшид 15 оюутан ногдох харьцааг бий болгохоор зорьж байгаа бол НУТ-ийн үзүүлэлт энэхүү зорилтот түвшинд бараг хүрээд байна. Жишээлбэл, 2015-2016 хичээлийн жилд 1 багшид ногдох оюутны тоо 16.7 байсан бол 2019-2020 онд 15.5. (Өөрийн үнэлгээний тайлан, Хүснэгт 6. 1. Нийтийн удирдлагын тэнхимийн багш суралцагчдын харьцаа, Хуудас. 77).
- ✓ Оюутны сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, оюутан, төгсөгчдийн ярилцлагаас үзэхэд тэнхимийн багш нарын мэдлэг, чадвар, харилцаа хандлагын байдалд сэтгэл ханамжтай байдаг байна (Оюутны ханамжийн судалгааны дүн, оюутан, төгсөгчдийн ярилцлага).

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

**Онцлог зүйл, туршлага:**

- ✓ МУИС нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүний нөөцийн бодлоготой, багшийн сонгон шалгаруулалтын нэгдсэн журамтай бөгөөд эдгээр нь Монгол Улсын Дээд боловсролын салбарын эрх зүйн баримт бичгүүдэд бүрэн нийцсэн.
- ✓ Төрийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч НУТ-ийн хувьд доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувь хэмжээ харьцангуй өндөр (56%), 2015 оноос жил дараалан өссөн байгаа нь сайшаалтай (33.3%);
- ✓ Түүнчлэн НУТ-ийн багш-оюутны харьцаа зохистой (нэг багшид 15.5 оюутан ногддог), МУИС-ийн 2016-2024 оны стратеги төлөвлөгөөний зорилтот түвшинг хангаад байна.

**Анхаарах асуудал:**

- ✓ Багшийн тоо тухайн мэргэжлээр суралцаж буй оюутны тооноос шууд хамааралтай, багшийн кредит цагийн ногдлоор тодорхойлогддог хэдий ч тэнхимийн хувьд багшийн тоо харьцангуй цөөхөн, хүн хүч дутмаг байгаа нь тэдний ажлын ачааллыг хэт ихэсгэж болохыг анхаарах;
- ✓ Тэнхимийн багшийн тоо цөөн байгаа нь зарим талаар оюутнуудад хүрч ажиллахад хүндрэл учруулдаг талаар оюутан, төгсөгчдийн ярилцлагын үеэр цөөнгүй удаа сул тал болон дурдагдаж байсныг анхааралдаа авах;

**Зөвлөмж:**

- ✓ Хөтөлбөрт элсэх оюутны тоог өсгөх замаар багш нарын орон тоог нэмэгдүүлэх боломжийг эрж хайх;



- ✓ Сургалтын ачааллыг харгалзан багшийн тоог нэмэгдүүлэх, докторын зэрэгтэй багшийг сонгон шалгаруулж авч ажиллуулахыг эрмэлзэх;

## **6.2 Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

### **Илрэл, нотолгоо:**

- ✓ МУИС нь “Багшийн хөгжлийн хөтөлбөр” (2019-2024) батлан мөрдөж байгаа ба Төрийн удирдлага хөтөлбөрийн багш нар үүний дагуу багшийн хөгжлийн хувийн төлөвлөгөөг гаргаж ажилладаг. Багшийн хөгжлийн хөтөлбөр нь МУИС-д проф, багш ажиллуулах журамд заасан албан тушаалын зэрэглэлд шаардагдах ур чадварыг эзэмшүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг тусгаж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг төлөвлөн, зарцуулах боломж олгож байна.
- ✓ Сургуулийн зүгээс багш нарыг хөгжүүлэхэд тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулж ирсэн байна. Тухайлбал, НУТ-ийн багш нарыг хөгжүүлэхэд жилд дунджаар 8.5 сая.төг. зарцуулсан нь сургалтын орлогын 2.5 % -ийг эзэлж байна (Өөрийн үнэлгээний тайлан, Хуудас 78-79).
- ✓ Багшийг хөгжүүлэхэд сургууль, ялангуяа тэнхимийн удирдлагын зүгээс ихээхэн анхаарч ирсэн ба багшийн хөгжлийг дэмжих сургалт, судалгааны төсөл, хөтөлбөрүүдийг дотоод, гадаадын мэргэжлийн байгууллага, их сургуулиудтай хамтран хэрэгжүүлж иржээ.
- ✓ Сургуулиас КОИСА-ийн санхүүжилтээр БНСУ-ын Хансон Их Сургуультай хамтран 2016-2018 онуудад хэрэгжүүлсэн “Нийтийн удирдлагын танхимын чадавхыг дээшлүүлэх төсөл нь тэнхимийн багш нарыг хөгжүүлэх, ялангуяа цахим сургалтын техник, технологийг эзэмшихэд багагүй үүрэг гүйцэтгэсэн байна.
- ✓ НУТ-ийн багш нар сүүлийн 5 жилд Вьетнам, ХБНГУ, Франц, Англи, БНСУ зэрэг улсуудад урт, богино хугацааны сургалтад хамрагдаж мэргэжил дээшлүүлжээ.
- ✓ Тус тэнхим нь АНУ, ХБНГУ, БНСУ, Камбожийн хаант улсын судалгааны институт, их сургуулиудтай хамтын ажиллагааны гэрээний дагуу нягт хамтран ажиллаж ирсэн. Энэ хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй эрдэмтэн, профессорууд НУТ-д зөвлөх болон зочин профессороор ажилладаг ба тэнхимийн багш нар тэдний туршлагаас суралцах, зөвлөгөө авах зэргээр мэдлэг, ур чадваруудыг сайжруулан ажиллаж байна.

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

### **Онцлог зүйл, туршлага:**

- ✓ МУИС-ийн хувьд хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг явуулах хүний нөөцийн тогтвортой бодлоготой, багш нарыг чадавхжуулах хөгжлийн хөтөлбөртэй.
- ✓ Багш нарыг хөгжүүлэх чиглэлээр, ялангуяа тэнхимийн удирдлагын зүгээс ихээхэн идэвх чармайлт гаргаж, гадаадын их дээд сургуулиуд, олон улсын

байгууллагуудтай нягт хамтран ажиллаж ирсэн нь зохих үр дүнгээ өгч, ихэнх багш нар гадаадад магистр, докторын зэрэг хамгаалсны дээр залуу багш мөн суралцаж байна.

- ✓ НУТ-ийн хувьд сүүлийн жилүүдэд багш нарын мэргэжил дээшлүүлэх тал дээр ихээхэн анхаарч ажиллаж байгаа нь сайшаалтай.

#### ***Анхаарах асуудал:***

- ✓ Багшийн хөгжилд зарцуулах санхүүжилтийн хэмжээ бага, төсвийн эх үүсвэр дутмаг;

#### ***Зөвлөмж:***

- ✓ НУТ-ийн зүгээс багшийг хөгжүүлэх, мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх талаар баримталж ирсэн бодлого, хэрэгжүүлж ирсэн олон талт үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэх;
- ✓ Сургуулийн зүгээс багшийн хөгжилд зарцуулах санхүүжилтийн хэмжээ, төсвийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

### ***6.3 Эрдэм шинжилгээ, судалгаа***

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

#### ***Илрэл, нотолгоо:***

- ✓ Их сургуулиуд, тэр дундаа МУИС-ийн хувьд эрдэм шинжилгээ, судалгаа нь багш нарын зайлшгүй хэрэгжүүлэх нэг үндсэн үйл ажиллагаа байдаг ба багш ажиллуулах журамд зааснаар МУИС-ийн багш нь Сургалт (А), Эрдэм шинжилгээ (Б), Бусад ажил (сургууль, нийгэм, олон нийтэд хандсан үйл ажиллагаа) зэрэг үндсэн 3 төрлийн ажлыг гүйцэтгэх үүрэгтэй.
- ✓ НУТ-ийн багш нар эрдэм шинжилгээ судалгааны ажил гүйцэтгэх, бүтээл нийтлүүлэх талаар ихээхэн идэвхтэй ажиллаж, сүүлийн жилүүдэд гадаад, дотоодод нийтлүүлсэн ЭШ-ний бүтээлийн тоо нэмэгдсэн байна.
- ✓ Тэнхимийн зүгээс гадаад, дотоодын цөөнгүй төсөл, хөтөлбөр хэрэгжүүлжээ. Тухайлбал, “GIZ Mongolia” байгууллагын захиалгаар 9 гэрээт төсөл, “GIZ Cambodia” байгууллагатай хамтран 3 гэрээт төсөл, Конрад Аденауэр Сантай хамтран “Засаглалын чадавхыг бэхжүүлэх судалгаа”, “Тогтвортой хөгжил” бүтээл гаргах зэрэг төсөл хэрэгжүүлсэн бол НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр UNDP байгууллагын “Иргэн төвтэй төрийн мэргэшсэн үйлчилгээ” чадавхыг бэхжүүлэх төсөлд оролцож байна.
- ✓ Сургуулиас хэрэгжүүлсэн Нийтийн удирдлагын тэнхимийн чадавхыг бэхжүүлэх төслийн хүрээнд ISSN 2586-355X индекстэй “IJPAC- International Journal of Public Administration and Consulting” мэргэжлийн сэтгүүлийг 2017 оноос эхлэн жилд 2 удаа гаргаж байна.
- ✓ Төрийн удирдлага хөтөлбөрийн багш нар 2016-2019 онуудад хамтарсан болон үндсэн зохиогчоор оролцож нийт 9 ном, сурах бичиг хэвлүүлж, зохиогчийн эрхийн гэрчилгээ авчээ.

- ✓ МУИС-аас багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор багц цагийн нэмэгдэл болон судалгааны ажил бичих, мэдээлэл цуглуулах зэрэг үйл явцыг дэмжих санхүүжилтийг олгодог (ӨҮТ, ЭШ-ний төсөв, зардал, хуудас 82-83, Хүснэгт 6. 2. “Төрийн удирдлага” хөтөлбөрийн багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулсан зардал).

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

**Онцлог зүйл, туршлага:**

- ✓ НҮТ-ийн багш нар эрдэм шинжилгээ судалгааны ажил гүйцэтгэж, бүтээл нийтлүүлэх талаар ихээхэн идэвх санаачилгатай, үр бүтээлтэй ажиллаж ирсэн;
- ✓ Тэнхимийн зүгээс гадаадын зөвлөх профессоруудтай хамтран NUM LEADERSHIP CONFERENCE, “UB IMPULSE” зэрэг олон улсын томоохон хурал, арга хэмжээг жил тутам уламжлал болгох зохион байгуулж ирсэн нь сайшаалтай.
- ✓ ISSN 2586-355X индекстэй “IJPAC- International Journal of Public Administration and Consulting” мэргэжлийн сэтгүүлийг 2017 оноос эхлэн жилд 2 удаа гаргаж байгаа нь чухал туршлага болж байна.
- ✓ Тэнхимийн хувьд хэдийгээр багшийн тоо харьцангуй цөөн боловч олон улсын байгууллагууд (GIZ, UNDP, KOICA г.м.), гадаадын их сургуулиуд (Герман, Өмнөд Солонгос гэх мэт орнуудын их сургуулиуд)-тай хамтран цөөнгүй төсөл хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн нь сайшаалтай бөгөөд энэ нь багш, оюутны сургалт, судалгааны ажлын үр нөгөөг дээшлүүлэхэд томоохон түлхэц үзүүлжээ.

**Анхаарах асуудал:**

- ✓ Эрдэм шинжилгээний ажилд зарцуулах санхүүгийн эх үүсвэр хязгаарлагдмал;
- ✓ Багш нарын сургалтын цагийн ачаалал их байдгаас өөрсдийгөө хөгжүүлэх, эрдэм шинжилгээний ажил хийх боломж бага;

**Зөвлөмж:**

- ✓ Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажилд үзүүлэх дэмжлэгийг сайжруулах, зардлын хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарах;
- ✓ Багш нарын сургалтын ачааллыг зохистой болгох замаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэх;
- ✓ Багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийг олон улсын чансаа өндөртэй сэтгүүлд хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

**6.4 Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

**Илрэл, нотолгоо:**

- ✓ МУИС-ийн профессор, багшийн ажлын гүйцэтгэлийг багц цагаар тооцож, үнэлэх ба хичээлийн жилд 26 багц цагийн сургалт, эрдэм шинжилгээ, сургууль олон нийтийн ажил гүйцэтгэх нормтой бөгөөд дотоод харьцаа нь албан тушаалын зэрэглэлээс хамаарч ялгаатай тогтоогдсон байдаг.
- ✓ МУИС-ийн хөдөлмөрийн дотоод журмын 6.2-т зааснаар багшийн нэг өдрийн танхимын хичээлийн цагийн ачаалал ажлын 8 цагаас, нэг улирлын сургалтын ачаалал (А) нь хичээлийн жилийн сургалтын заавал гүйцэтгэх нийт цагийн 70%-аас хэтрэхгүй байна. Тодорхой шалтгааны улмаас шаардлагатай гэж үзвэл А цагийн хэмжээг бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн нэмэгдүүлж болно гэсэн заалттай.
- ✓ Хичээлийн жилийн төгсгөлд багш гүйцэтгэсэн ажлын тайлан бичиж, нотлох баримтуудыг хавсарган тэнхимийн эрхлэгчид хүлээлгэн өгдөг.
- ✓ МУИС-д профессор, багш ажиллуулах журмын 14-т заасны дагуу багш нарын ажлын гүйцэтгэлийн дүнг Сургалтын нэгдсэн алба хянах ба нэгдсэн дүнг Захиргаа хяналт шинжилгээний албанд хүргүүлэн хянуулах ба улмаар МУИС-ийн Захиргааны зөвлөлөөр хэлэлцэн дүгнэж, багшийн ажлын гүйцэтгэл бүрэн биелсэн нөхцөлд ээлжийн амралт олгох шийдвэр гардаг. Түүнчлэн багшийн өөрийн үнэлгээний тайланг үндэслэн тухайн багшийн ажиллах албан тушаалын зэрэглэлийг тогтоох ажил хийгдэнэ. Ингэхдээ тэнхимийн хурлаар багшийн тайланг хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гарган бүрэлдэхүүн/салбар сургуульд уламжилдаг.
- ✓ Профессор, багшийн ажлын үнэлгээнд оюутны үнэлгээ багагүй үүрэгтэй байдаг ба оюутнуудын сэтгэд ханамжийн судалгааны хүрээнд хичээл тус бүрээр үнэлгээ гардаг. НУТ-ийн оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаанаас үзэхэд тэнхимийн багш нарын үнэлгээ харьцангуй өндөр байна.
- ✓ Багшийн хөндлөнгийн үнэлгээг хичээлийн жилийн төгсгөлд багшийн хичээлд хамрагдсан оюутнуудын сэтгэл ханамжийн судалгааны дүн, багшийн ажлын нэгдсэн үнэлгээ (аттестатчилал) – ний үр дүнгээр гаргадаг.
- ✓ МУИС-ийн хэмжээнд профессор, багшийн тухайн албан тушаалын зэрэглэлд тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, үнэлгээ тогтоодог гол арга нь аттестатчилал байдаг. “Аттестатчиллын журам” –аар профессор, багшийн зайлшгүй гүйцэтгэвэл зохих үүрэгт ажлыг үнэлэх, дүгнэх, үр дүнг тооцох асуудлыг зохицуулах ба гол зорилго нь багш тухайн албан тушаалын зэрэглэлд тавигдах шаардлагыг хэрхэн хангаж байгааг тогтооход чиглэгддэг.
- ✓ Дээрхээс гадна МУИС-д “Багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм” –ийг мөрдөж ажилладаг ба энд сургалт, судалгаа, нийгмийн үйлчилгээний хүрээнд мэргэжлийн ёс зүй, суралцагч болон хамт олонтой харилцах хүрээнд харилцааны ёс зүйн хэм хэмжээг тогтоосон байдаг.
- ✓ МУИС-ийн хувьд профессор, багш нарын ажлыг гүйцэтгэлийг тооцож, төлөвлөх, үнэлэх нэгдсэн журам баримталдаг, үнэлгээний тогтсон арга механизмтай бөгөөд багшийн үнэлгээг харьяалах шууд удирдлагын үнэлгээ, өөрийн үнэлгээ, оюутны үнэлгээ зэрэг олон талын үнэлгээг харгалзан гаргаж байна.
- ✓ Ажлын гүйцэтгэлийн үнэлгээг харгалзан багш нарт урамшуулал олгодог. Урамшууллын хэмжээг тухайн багшийн өөрийн үнэлгээ, хамт олны үнэлгээ,

удирдлагын үнэлгээ, оюутны үнэлгээний дунджаар тодорхойлдог. Нийтийн удирдлагын тэнхимийн багш нарт 2018 онд 4.9 сая төг., 2019 онд 6.2 сая төг.-ийн урамшуулал олгосон байна.

#### *Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

##### **Онцлог зүйл, туршлага:**

- ✓ НУТ-ийн багш нарын хувьд оюутны үнэлгээ сүүлийн 5 жилд тогтмол сайн. 75%-аас дээш үзүүлэлттэй, дунджаар 82.7 %-тай гарсан үр дүнтэй байна;
- ✓ НУТ-ийн удирдлагын үйл ажиллагаа зохион байгуулалт сайтай. Үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтад (i) хууль дүрэм, журам, тушаал, (ii) гадаад, дотоод хамтын ажиллагаа, (iii) үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, (iv) сургалт, (v) судалгаа, (vi) оюутанд чиглэсэн үйл ажиллагаа, (vii) мэдээ, мэдээлэл (viii) хүний нөөц, (ix) төсөв санхүү, болон (x) бусад үйл ажиллагаа зэргийн талаарх мэдээллийг 10 төрлийн хавтсыг хөтлөн, хадгалж, ашигладаг ба тэнхимийн багш нар мөн холбогдох баримт материалын хавтасыг бүрдүүлж, сүүлийн 3 жилд ашиглаж хэвшсэн нь тэнхим болон багш нарын ажлын үр дүнд эергээр нөлөөлсөн байна.

##### **Анхаарах асуудал:**

- ✓ Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тайланд тусгасан байдал хангалтгүй байгааг анхаарах;
- ✓ Өөрийн үнэлгээний тайланд дурдсанчлан, багш нарын сургалтын цагийн ачаалал их, багш нар өөрсдийгөө хөгжүүлэх, эрдэм шинжилгээний ажил хийх боломж бага, МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм, Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмын хэрэгжилт сул, багш нарт олгож буй урамшууллын шалгуур тодорхойгүй, багш нарын ур чадварын хөгжил хөтөлбөрийн сургалтын сайжруулалтад эерэг үр дүн авчирч буйг үнэлэх шаардлагатай байгаа зэргийг анхаарах;

##### **Зөвлөмж:**

- Дээр дурдсан анхаарвал зохих асуудлуудыг шийдвэрлэхийг зорих;
- Багш нар оролцож буй төсөл, судалгаа шинжилгээний ажлын үр дүнг хөтөлбөрийг сайжруулахад ашиглах, тэдний заах арга зүйн ур чадварыг дээшлүүлэх бодлого, үйл ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлэх;
- Багшийн ажлын гүйцэтгэлд тулгуурласан урамшууллын системийг боловсронгуй болгох;

#### ***Зургаадугаар шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:***

**“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”**

#### **ШАЛГУУР 7. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

##### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

***Илрэл, нотолгоо:***

- ✓ Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг хичээлийн жилд тусгайлан гаргасан хуваарийн дагуу тэнхим хариуцан хэрэгжүүлдэг, хөндлөнгийн баталгаажуулалтыг МУИС-ийн Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс /2017 онд байгуулагдсан/ эрхлэн явуулж байна. /ӨҮТ, хуудас 91, Хүснэгт 7.1/ Энэ хэлтэс нь хөтөлбөрт үнэлгээ хийх журам боловсруулах, хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын үнэлгээний тогтолцоог боловсруулах, хөтөлбөрийн үнэлгээний нэгдсэн тайланг боловсруулан мөрдүүлэхээр ажиллаж байна. Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтсийн 2018-2019 оны нэгдсэн төлөвлөгөөнд мэргэжлийн хөтөлбөр боловсруулах, баталгаажуулах, үнэлэх, дүгнэхтэй холбогдсон эрх зүйн нэгдсэн зохицуулалтыг бий болгоход чиглэгдсэн “Хөтөлбөрийн болон үнэлгээний журам боловсруулах, Сургалтын хөтөлбөр боловсруулах удирдамж гаргах” гэсэн 2 арга хэмжээ орсон боловч одоогоор ажлын хэсгийн боловсруулалтын шатанд байна .
- ✓ Төрийн удирдлага хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнуудаас авсан судалгаагаар багшийн үйл ажиллагаанд 81.3 хувь нь, сургалтын орчинд 80.8 хувь нь, хичээлийн байдалд 79.8 хувь нь, төгсөгчдийн 38.1 хувь нь бүрэн сэтгэл ханамжтай байна.
- ✓ Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаа эхлэлийн байдалтай байна. Тухайлбал, дотоодын баталгаажуулалт (тэнхимд) Багшийн хичээлд суух, Залуу багш нарт заавар, зөвлөгөө өгөх, аттестатчилалд оруулах, сурлагын үнэлгээний мэдээ, тайланг ХЧБХ-т өгч байна. Хөндлөнгийн баталгаажуулалтын хувьд МУИС-ийн захирлын 2018 оны А/452 дугаар тушаалаар Хөтөлбөрийн журам боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан, энэ ажлын хэсэг хөтөлбөрийн шинэ бүтэц, чанарын баталгаажуулалтын талаар баримтлах бодлого, үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлон батлуулахаар ажиллаж байна.

*Шалгуурыг хангасан байдал: “ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН”*

***Анхаарах асуудал:***

- ✓ Төрийн удирдлага хөтөлбөрийн дотоодын болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаа (бүрэлдэхүүн сургуулиудын) нь МУИС-ийн хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоо, үйл ажиллагааны механизмаас шууд хамааралтайг анхааран үзэх.

***Зөвлөмж:***

- ✓ Эхний удаад **“МУИС-ийн хэмжээний бакалаврын мэргэжлийн хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоо, үйл ажиллагааны механизм”-ыг** боловсруулан баталгаажуулж, салбар сургуулиудад мөрдүүлэхийг зөвлөмж болгож байна.

## 7.2 Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

### **Илрэл, нотолгоо:**

- ✓ Төрийн удирдлага хөтөлбөрт 2014-2017 онд төгсөгчдийн ажил эрхлэлт, ажлын байрны нийцэл, хангалт, карьер өсөлтийн дундаж хугацааг тодорхойлох, ТАХ-ийн шалгалт өгсөн, мэргэжлээрээ ажиллаж байгаа болон тухайн байгууллагад ажиллаж байгаа хугацааны байдлаар судалгаа авч дүгнэжээ. Судалгааны дүнгээс үзэхэд төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдлыг 2018, 2019 онд 2 үе шатаар явуулахад мэргэжлээрээ ажиллаж байгаа 24 хувь, үргэлжлүүлэн суралцсан 13 хувь, мэргэжлээрээ ажиллаагүй 63 хувь, 25 хувь нь ТАХ-ийн шалгалт өгсөн, 21.4 хувь нь 1-3 сараар, 25 хувь нь 1-2 жил, 3,6 хувь нь 3 ба түүнээс дээш жил ажиллаж байна. Ажил олгогчдын судалгаагаар Төрийн удирдлага хөтөлбөрөөр төгсөгчдийн мэдлэгийг 40 хувь нь, ур чадварыг 50 хувь нь, хандлагыг 30 хувь нь маш сайн гэж үнэлжээ (ӨҮТ, хуудас 96-99).
- ✓ Төрийн удирдлага мэргэжлээр сүүлийн 5 хичээлийн жил (2015-2016-аас 2019-2020 оны)-д суралцаж байгаа оюутны сурлагын амжилтын дундаж голч дүн 3.0, төгсөгчдийн сурлагын амжилтын дундаж голч дүн мөн 3.0 байна (ӨҮТ, хуудас 101).
- ✓ Нийтийн удирдлагын тэнхимээс эрхлэн БНСУ-ын KOICA байгууллагын хөрөнгө оруулалтаар цахим сургалтын танхим байгуулсан, Олон улсын ЭШ-ний хурал, семинар, хэлэлцүүлгийг үндэсний хэмжээнд тогтмол зохион байгуулдаг, Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн судлаачид, профессоруудыг тэнхимдээ урьж “Зөвлөх профессор”, судлаачаар ажиллуулдаг, гадаадын их, дээд сургуулиудтай тогтоосон хамтын ажиллагааны хүрээнд төгсөгчдөө магистр, докторын сургалтын тэтгэлэгт хамруулдаг, Монгол Улсын төрийн албаны зөвлөлтэй үйл ажиллагааны хэд хэдэн чиглэлээр хамтран ажилладаг зэрэг нь суралцагчид, төгсөгчдийн сэтгэл ханамжийг бий болгодог төдийгүй элсэгчдийг татах нэг хүчин зүйл болж байна (ӨҮТ, хуудас 106,109. Хүснэгт 7.10).
- ✓ Шинжээчид хөндлөнгийн үнэлгээ хийх явцдаа Төрийн удирдлага хөтөлбөрөөр суралцаж байгаа 17 оюутнаас Төрийн удирдлага хөтөлбөрийн юунд нь сэтгэл ханамжтай байдаг вэ? Энэ хөтөлбөрийн юунд нь сэтгэл дундуур байдаг вэ? Энэ хөтөлбөрийн агуулга, аргазүй, үр дүнг дээшлүүлэхэд юуг анхаарах, ямар сайжруулалт хийх саналтай байна вэ? гэсэн 3 асуулт, 13 төгсөгчөөс Төрийн удирдлага хөтөлбөр эрхэлсэн ажлын байрны шаардлагыг хэр хангаж (давуу, сул тал) байна вэ?, Энэ хөтөлбөрийн агуулгын багтаамж, сургалтын арга, үр дүн (мэдлэг, чадвар, хандлага)-д ямар сайжруулалт хийх шаардлагатай байна вэ? гэсэн 2 асуулт, 11 ажил олгогчоос Төрийн удирдлага хөтөлбөрөөр төгсөгчид танай байгууллагын ажлын байрны шаардлага (онолын мэдлэг, чадвар, хандлага)-ыг хэр хангаж байна вэ? Энэ хөтөлбөрийн агуулга, арга зүй, үр дүнг дээшлүүлэхэд юуг анхаарах, ямар сайжруулалт хийх саналтай байна вэ? гэсэн

2 асуултын дагуу онлайнаар ярилцлага хийхэд энэ хөтөлбөрөөр олгож байгаа мэдлэг, чадвар, хандлагад суралцагчид, төгсөгчид, ажил олгогчид сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлж, цаашид төрийн удирдлагын үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжүүлэлт, тайлагнал, чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд хөтөлбөрийн үр дүнг чиглүүлэх, хөрвөх чадвар бий болгох, хөтөлбөрийн маркетинг, элсэлтийг нэмэгдүүлэх, хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан богино хугацааны сургалт зохион байгуулж байхад анхаарахыг санал болгож байв.

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

**Анхаарах асуудал:**

- ✓ Хөтөлбөрийн үр дүн, сурталчилгаа, элсэлтийг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулах

**Зөвлөмж:**

- ✓ Хөтөлбөрийн сайжруулалтад төгсөгчдийн “Төрийн удирдлага” хөтөлбөрийн мэргэжлийн цогц ур чадвар, хөрвөх хувилбарыг тодруулан оруулахыг зөвлөж байна.

**7.3 Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

**Илрэл, нотолгоо:**

- ✓ Төрийн удирдлага хөтөлбөр 2011 оноос эхлэн хэрэгжиж байгаа бөгөөд өмнө нь үндэсний болон олон улсын түвшинд магадлан итгэмжлэгдээгүй, анх удаа магадлан итгэмжлэлд орж байна. Энэхүү хөтөлбөр нь манай улсын олон жилийн түүхтэй ууган сургууль болох МУИС-ийн нэгэн салбар сургуульд хэрэгждэг, Сургалтын хөтөлбөрийн төлөвлөлт, Сургалтын үйл ажиллагаа, Хөтөлбөрийг хэрэгжүүлэх орчин, Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа, Багшийн чадавх, үйл ажиллагаа нь үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх боломжтой байна.
- ✓ Мөн Олон улсын ЭШ-ний хурал, семинар, хэлэлцүүлгийг үндэсний хэмжээнд тогтмол зохион байгуулдаг, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн судлаачид, профессоруудыг тэнхимдээ урьж “Зөвлөх профессор”, судлаачаар ажиллуулдаг, гадаадын их, дээд сургуулиудтай тогтоосон хамтын ажиллагааны хүрээнд төгсөгчдөө магистр, докторын сургалтын тэтгэлэгт хамруулдаг, Монгол Улсын төрийн албаны зөвлөлтэй үйл ажиллагааны хэд хэдэн чиглэлээр хамтран ажилладаг, БНСУ-ын Hansung их сургуультай хамтран олон улсын стандарт ISSN 2586-355X дугаартай International Journal of Public Administration and consulting /IJPAC/ сэтгүүльд NUM Leadership ОУ-ын ЭШХ-ын эмхэтгэлийг жил бүр тогтмол хэвлүүлдэг болсон зэрэг нь МУИС-ийн ОУХНУС-ийн “Төрийн



удирдлага” мэргэжлийн бакалаврын хөтөлбөрийг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдэж байгааг нотолж байна.

*Шалгуурыг хангасан байдал: “БҮРЭН ХАНГАСАН”*

***Онцлог зүйл, туршлага:***

- ✓ Гадаадын их сургууль, ОУБ-тай хамтран ажилладаг, нэр хүндтэй профессор, судлаачдыг урьж, зөвлөх профессор, судлаачаар ажиллуулдаг, олон улсын эрдэм шинжилгээний хурал, семинар, хэлэлцүүлгийг үндэсний хэмжээнд тогтмол зохион байгуулдаг.

***Анхаарах асуудал:***

- ✓ Төгсөгчдийг мөшгөх судалгааг тодорхой хугацааг хамруулан хийж, үр дүнг хөтөлбөрийн сайжруулалтад тухай бүрд нь тусгаж байх.

***Зөвлөмж:***

- ✓ Энэхүү хөтөлбөрийн агуулгын багтаамж, сургалтын орчин, арга зүй, хөтөлбөрийн үр дүнг үе шаттайгаар боловсруулж, улмаар “Төрийн удирдлага” бакалаврын мэргэжлийн хөтөлбөрийг ОУ-ын түвшинд магадлан итгэмжлүүлэх бэлтгэлийг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэхийг зөвлөж байна.

***Долоодугаар шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:***

**“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”**

## ДҮГНЭЛТ

МУИС-ийн ОУХНУС-ийн Төрийн удирдлага хөтөлбөрийн агуулга, арга зүй, төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлага, сургалтын орчин, профессор, багшийн хангамж, сургалтын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, суралцагч, төгсөгч, ажил олгогчдын сэтгэл ханамжийн түвшин, хөтөлбөрийн хүрээнд гадаад, дотоодын их сургууль, олон улсын байгууллагатай хамтын ажиллагаа тогтоож, хөтөлбөр, төсөлд оролцож байгаа зэрэг нь энэхүү хөтөлбөр үндэсний хэмжээний бакалаврын мэргэжлийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шаардлагыг хангаж байна.

№	Шалгуур	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн болон хангаагүй тохиолдолд заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшийн үйл ажиллагаа	2			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			

Баримт материал, нотлох баримт, уулзалт, ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг МУИС-ийн ОУХНУС-ийн “Төрийн удирдлага” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур, шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Бизнес, удирдлагын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч

доктор, проф. Ц.Гэлэгжамц

Шинжээчийн багийн гишүүн

доктор, проф. Л.Оюунцэцэг

Шинжээчийн багийн гишүүн

доктор, дэд проф. Я.Бямбаяр

## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	МУИС-ИЙН ОУХНУС
Хөтөлбөрийн нэр	ТӨРИЙН УДИРДЛАГА
Хөтөлбөрийн индекс	D041303
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>“Төрийн удирдлага” хөтөлбөрийн холбогдох баримт бичгүүдийг хэсэгчлэн шинэчлэн боловсруулсныг БСШУ-ны сайдын 2014 оны А/174 дүгээр тушаалаар баталсан нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн байдлаар боловсруулж, баталгаажуулан мөрдөх.</li> <li>21-р зууны дээд боловсролын шинэчлэл, тогтвортой хөгжлийн зорилтууд, мэдээллийн технологийн хөгжил, цахим засаглал, дижитал хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд нийцүүлэн хөтөлбөрийн зорилго, зорилт /2014 он/-ыг шинэчлэн тодорхойлох.</li> </ul>
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>Зайн сургалтын арга зүйд сургах, үнэлгээний аргачлалыг хичээл бүрийн хэлбэр, онцлог, агуулгад нийцүүлэн боловсруулах.</li> </ul>
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> <li>Хичээлийн байранд оюутны цайны газар, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч зорчих стандарт нөхцөлийг бий болгох, интернетийн хүчин чадлыг нэмэгдүүлэх.</li> </ul>
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> <li>Ажил олгогчдын болон төгсөгчдийн төлөөллийг Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулахад санаачилга гарган ажиллах.</li> </ul>
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> <li>Оюутнуудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын оролцоо, үр нөлөөг нэмэгдүүлэх.</li> <li>Оюутны сайн дурын ажлыг идэвхжүүлэх, үнэлэх нэгдсэн тогтолцоо, зохицуулалттай болох.</li> </ul>
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>Багш нарын сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зохистой харьцаа, ачааллыг оновчтой тогтоож мөрдүүлэх, багшийн хөгжилд зориулсан санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх.</li> </ul>
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> <li>МУИС-ийн хэмжээнд бакалаврын мэргэжлийн хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоо, үйл ажиллагааны механизмыг шинэчлэн боловсруулж, баталгаажуулан мөрдөх.</li> <li>“Төрийн удирдлага” бакалаврын хөтөлбөрийг олон улсын түвшинд магадлан итгэмжлүүлэхэд бэлтгэл ажлыг ханган ажиллах.</li> </ul>
<b>ШААРДЛАГА /хэсэгчлэн хангасан шалгуур, дэд шалгуурт заавал шаардлага бичнэ/</b>	
Дэд шалгуур 4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт	<ul style="list-style-type: none"> <li>Хөтөлбөрийн агуулга, арга зүй, үр дүн, ажлын байрны хэрэгцээ, хангамжийн талаарх сурталчилгаа /маркетингийн идэвхжүүлэлт/-ны арга, хэлбэрийг боловсронгуй болгох.</li> </ul>
Дэд шалгуур 7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт	<ul style="list-style-type: none"> <li>МУИС-ийн Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтсийн 2018-2019 оны хичээлийн жилийн нэгдсэн төлөвлөгөөнд орсон боловч одоогоор ажлын хэсгийн боловсруулалтын шатанд байгаа “Хөтөлбөрийн болон үнэлгээний журам”, “Сургалтын хөтөлбөр боловсруулах удирдамж”-ийг 2020-2021 оны хичээлийн жилийн эхний хагаст багтаан эцэслэн боловсруулж, баталж мөрдөх.</li> </ul>

## IV. ЯРИЛЦЛАГАД ОРОЛЦОГЧДЫН НЭРС

### 1) Багш нар

№	Нэр	Албан тушаал	Зэрэг, цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Г.Баасанжав	НУ-ын тэнхимийн эрхлэгч	Доктор		
2	Н.Бурмаа	профессор	Доктор, профессор		
3	Б.Баттогтох	багш	Магистр		
4	Г.Мягмар	багш	Магистр		
5	Т.Ганчимэг	Багш	Магистр		

### 2) Оюутнууд

№	Нэр	Курс	Харьяалал
1	Мягмарын Батдорж	4	Дорнод, Хэрлэн
2	Жаргалсайханы Должин	4	Улаанбаатар
3	Чуваасүрэнгийн Энхтунгалаг	4	Төв, Борнуур
4	Жанцандоржийн Гарамханд	4	Завхан, Их-Уул
5	Батболдын Ичинноров	4	Дундговь, Адаацаг
6	Батбилэгийн Буянзаяа	3	Дорноговь, Сайншанд
7	Цэвээндоржийн Алтансүх	3	Булган, Сэлэнгэ
8	Батсүхийн Батхишиг	3	Улаанбаатар
9	Ёндонжамцын Адьяалхам	3	Хөвсгөл, Жаргалант
10	Тамираагийн Мөнхзаяа	2	Улаанбаатар
11	Хишиг-Ундралын Гүнбилигт	2	Улаанбаатар
12	..... Энх-Оргил	...	....
13	..... Батсүрэн	...	....
14	Цэрэнсодномын Дулмаа	3	Өвөрхангай, Арвайхээр
15	Баянжаргалын Зулсар	3	Өмнөговь, Даланзадгад
16	Батбаярын Сарангоо	2	Дорноговь, Улаанбадрах
17	Батсүрэнгийн Булган	4	Баянхонгор, Бууцагаан

### 3) Ажил олгогчид



№	Нэр	Байгууллага	Албан тушаал
1	Ч.Жавзанпагма	Төв аймгийн ИТХ	Нарийн бичгийн дарга, Ажлын албаны дарга
2	С.Цэдэндамба	Монгол Улсын Төрийн албаны зөвлөл	Гишүүн
3	Б.Баярсайхан	Үндэсний хөгжлийн газар	Дарга
4	Ч.Сүрэнхорол	Өмнөговь аймгийн ЗДТГ	ХШҮДА-ын хэлтсийн дарга
5	Б.Номин	Голомт Банк	Шангри-Ла салбарын захирал
6	Г.Батбаатар	Хаан Банк	Эрсдэл хариуцсан захирлын ахлах орчуулагч

7	Э.Даваахатан	Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар	Гадаад харилцаа, хамтын ажиллагааны ажилтан
8	Л.Сайнгэрэл	Булган аймгийн Хангал сумын ЗДТГ	Тамгын газрын дарга
9	Г.Банзрагч	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Бодлого төлөвлөлтийн газрын дарга
10	О.Батболд	Камбожийн Вант улс дахь GIZ төлөөлөгчийн газар	
11	Ж.Ганбат	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ИТХ	Зохион байгуулалтын хэлтсийн дарга

#### 4) Төгсөгчид

№	Нэр	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Б.Чойжилгарав	2015	Монгол Улсын Төрийн албаны зөвлөл	Ахлах мэргэжилтэн
2	Д.Отгонжаргал	2015	Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар	Мэргэжилтэн
3	Д.Хонгорзул	2015	Булган аймгийн Хангал сумын ЗДТГ	Мэргэжилтэн
4	Н.Цэрмаа	2015	Аласкийн Их сургууль АНУ, Анкориж	Докторант
5	Ч.Ундрам	2016	Бот Макс Компани	Маркетингийн менежер
6	Б.Будгариг	2016	Голомт Банк	Шангри-Ла салбарын харилцааны менежер
7	Б.Амгалан	2017	GIZ	IMRI төслийн туслах мэргэжилтэн
8	Д.Ууганбаяр	2017	Өмнөговь аймгийн ЗДТГ	Мэргэжилтэн
9	А.Хуралай	2017	Хаан Банк	Эрсдэл хариуцсан дэд захирлын орчуулагч
10	У.Тэмүүл	2018	Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Иргэний улсын бүртгэгч
11	С.Ариунбилэг	2018	Хөгжлийн Банк	Нарийн бичгийн даргын туслах
12	О.Өнөрбилэг	2018	Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар	Мэргэжилтэн
13	Д.Баасандорж	2019	Төв аймгийн ИТХ	Хурлын даргын туслах

## V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал /албан бичгийг оруулах/

 <b>МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ</b> 14201 Улаанбаатар хот-46/а ш/х-6, Сүхбаатар Дүүрэг, Баян модруу 5, Утас/Факс: (976-11) 35-46-10, E-mail: sirpa@num.edu.mn, http://sirpa.num.edu.mn <u>2020.09.23</u> № <u>09/29</u> танай _____ -ны № _____ -т	<b>БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД</b>
<b>Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шинжээчийн тайланд санал хүргүүлэх тухай</b>	
<p>Тус сургуулийн Төрийн удирдлага (Нийтийн удирдлага)-ын бакалаврын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх "Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл"-өөс томилогдсон шинжээчдийн 2020.06.09-10-ны өдрүүдэд ажилласан тайлан, дүгнэлттэй танилцлаа. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шинжээчдийн тайланд тусгасан зөвлөмжийг хүлээн авч, цаашид хөтөлбөрөө сайжруулахад анхаарч ажиллахаа үүгээр мэдэгдэж байна.</p> <p>Магадлан итгэмжлэлийн шаардлага 1.3-д тус бакалаврын хөтөлбөрийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 04-р сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаалаар баталсан шаардлагын дагуу боловсруулан, МУИС-ийн албан ёсны тамга тэмдгээр баталгаажуулан мөрдөх тухай зөвлөмж өгсөн байна. Үүнд дараах тайлбарыг хүргүүлж байна:</p> <p>МУИС-ийн дотоод дүрэм, журмаар зохион байгуулалтын анхан шатны нэгж болох тэнхим нь МУИС-ийн тамга тэмдэг ашиглах, хэрэглэх эрхгүй ба хөтөлбөрийг баталгаажуулах нэгдсэн зохицуулалтыг МУИС-ийн Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс (ХЧБХ) хариуцдаг. ХЧБХ нь нэгдсэн бодлогын дагуу сургалт явуулж буй бүх мэргэжлийн хөтөлбөр, хичээлийн төлөвлөгөө, стандарт боловсруулах, шинэчлэхэд туслалцаа үзүүлэх, хөтөлбөр батлах, мөрдүүлэхэд хяналт тавьж ажиллах чиг үүрэгтэй.</p> <p>Нийтийн удирдлагын тэнхим 2014 онд хөтөлбөрөө Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 04-р сарын 28-ны өдрийн А/174 тушаал мөн МУИС-ийн дүрмийн 4.5.5-д заасны дагуу сургалт, судалгааны үйл ажиллагааг үр ашигтай, хариуцлагатай удирдан зохион байгуулах үндсэн чиг үүргийн хүрээнд холбогдох дүрэм, журмын дагуу боловсруулан, МУИС-ийн хөтөлбөрийн Ерөнхий хороогоор хэлэлцүүлэн батлуулсан хөтөлбөрөө МУИС-ийн Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэст (ХЧБХ) 2014 онд хүлээлгэн өгсөн болно.</p> <p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 06-р сарын 29-ний өдрийн А/52 дугаар тушаалаар "Нийтийн удирдлага" хөтөлбөр нь "Төрийн удирдлага" болж зөвхөн нэршил өөрчлөгдсөн тул сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн агуулгад ямар нэгэн өөрчлөлт оруулаагүй болно. ХЧБХ-ээс албанаас өгсөн тайлбарыг хавсаргав.</p>	
33400041	
<p>Тус хөтөлбөрөөс 2017 онд шинэчлэгдсэн "Төрийн удирдлага" хөтөлбөрийн "бүрэлдэхүүн"-ийг боловсруулах ажлыг гүйцэтгэж байгаа болно.</p> <p>Тус хөтөлбөрийн "нэр"-тэй холбоотой өөрчлөлтүүдийн тухай</p> <ol style="list-style-type: none"><li>1. Тус хөтөлбөр анх МУИС-ийн Эдийн Засгийн Сургуулийн Эрдмийн Зөвлөлийн 2011 оны 09-р сарын 06-ны өдрийн хурлын шийдвэр, МУИС-ийн Захирлын 2012 оны 04-р сарын 20-ны өдрийн 210 тоот тушаалаар "Менеджмент, Төрийн захиргаа" нэртэйгээр бакалаврын түвшний сургалт явуулж эхэлсэн.</li><li>2. МУИС-ийн Захирлын 2014 оны 02-р сарын 03-ны өдрийн А/19 тоот "Шинэ бүтцийн тэнхимүүд байгуулах, бакалаврын хөтөлбөрийн харьяалал шинээр тогтоох" тухай тушаалаар харьяалал өөрчлөгдөн ОУХНУС-ийн бүтцэд харьяалагдах болсон ба улмаар хөтөлбөрийг Боловсрол Шинжлэх Ухааны Сайдын 2014 оны 3-р сарын 13-ны Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай А/78 тоот тушаал, МУИС-ийн Захирлын 2014 оны 07-р сарын 31-ний өдрийн А/259 тоот тушаалын дагуу "Нийтийн удирдлага" болгон өөрчилсөн.</li></ol> <p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 06-р сарын 29-ний өдрийн А/52 дугаар тушаалаар "Нийтийн удирдлага" хөтөлбөр нь "Төрийн удирдлага" нэртэй болсон.</p>	
ЗАХИРАЛ	 С.БАТТУЛГА

## ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) .....  
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**

## ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо) .....  
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа